

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2008-2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТУУДЫН ХЭРЭГЖИЛТ**

Завхан аймаг

2010.03.25

№	Зорилт-ын дугаар	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Биелэлт	Биелэлтийн хувь
1.1 Эрүүл мэндийн бодлого						
1	1.1.1.1	Эрүүл аж төрөх хэв маяг, эрүүл мэндээ хамгаалах зөв зан үйлийг төлөвшүүлж, хүн амын өвчлөл, нас баралтыг бууруулж, дундаж наслалтыг уртасгана.	Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүжилтийн механизмыг төв болон орон нутгийн түвшинд оновчтой болгоно.	2008-2012	Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, Аймгийн эдийн засаг, нийгмийг 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд “Хүн амын эрүүл мэндийг дэмжих тэдэнд эрүүл мэндийн боловсрол олгох, олон нийтэд эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулах” гэсэн зорилтыг тусгаж хэрэгжүүлсэн. “Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд чанартай хүртээмжтэй хүргэх” сэдэвт уулзалт зөвлөгөөн, Сумдын багийн бага эмч нарын “Эрүүл байхын төлөө хамтдаа” чуулга уулзалтыг зохион байгууллаа. Мөн Ерөнхий боловсролын сургуулиудын дунд эрүүл мэндийн уламжлалт олимпиад, “ Эрүүл аж төрөхөд бидний оролцоо” уриан дор зохион байгуулсан. Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа 17 хөтөлбөрийг Халдварт , халдварт бус өвчний чиглэлээр тус бүрийн хэрэгжилтийг Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн хурлаар хэлэлцэж, үнэлэлт дүгнэлт өгч, цаашид авах арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна.	50
2	1.1.1.3		Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын удирдамжийн дагуу эрүүл хот, дүүрэг, сум, баг, ажлын байр, сургууль бий болгох үндэсний хэмжээний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	2009-2010	Засаг даргын 67 дугаар захирамжаар батлагдсан аймгийн Эрүүл мэндийг дэмжих байгууллага шалгаруулах комиссын бүрэлдэхүүн 2008 онд “Эрүүл мэндийг дэмжигч” байгууллагыг шалгаруулж болзлыг дүгнэхэд: Эрүүл мэндийн газар , Сонгино сумын сургууль 1 дүгээр зэргийн болзлыг хангаж Гэрчилгээ тус бүр 300.0 / гурван зуун мянган / төгрөг, Тэлмэн сумын сургууль, Нөмрөг сумын хүн эмнэлэг, Сонгино сумын цэцэрлэг, ХААН банк, Улиастайн 4-р цэцэрлэг, Чандмань-эрдэнэ цогцолбор сургууль 2 дугаар зэргийн болзолыг хангаж, Гэрчилгээ, тус бүр 200.0 / хоёр мянган зуун / төгрөг, Нөмрөг сумын цаг уур, цэцэрлэг, Сонгино сумын тамгын газар, цэргийн анги, Цэцэн-уул сумын хүн эмнэлэг, цэцэрлэг, “Дэлгэрэх” нарийн	50

					боовний цех, Цагаанхайрхан сумын цэцэрлэг, сургууль, Дэвшил сургууль, Зэвсэгт хүчний 325-р анги тус тус 3 дугаар зэргийн болзлыг хангаж гэрчилгээ , тус бүр 100.0 / зуун мянган/ төгрөгөөр тус тус шагнагдан нийт 2860000 / хоёр сая найман зуун жаран мянган /төгрөг зарцуулсан.	
3	1.1.4.1	Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдэд төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламж үнэ төлбөргүй авах эрхийн бичиг олгоно.	Төлбөрийн чадваргүй, амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой иргэдэд төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламжийг үнэ төлбөргүй авах эрхийн бичиг олгох үр дүнтэй механизмыг судалж шийдвэрлэнэ.	2008-2012	Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, 2008, 2009 оны үндсэн чиглэлд Сумдын ард иргэдийг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулах заалтыг тусган оруулж, Баянтэс, Дөрвөлжин, Ургамал, Шилүүстэй, Идэр, Отгон, Их-Уул, Тосонцэнгэл, Эрдэнэхайрхан, Сантмаргац, Цэцэн-Уул сумдын ард иргэдийг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулж хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийн 2450 иргэнд үнэ төлбөргүй эмнэлгийн үйлчилгээ үзүүллээ.	50
4	1.1.5.2	Эрүүл мэндийн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, төрийн оролцоог багасгах зорилгоор хүн амд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулахад хувийн хэвшлийн мэргэжлийн эмнэлгийн оролцоог дэмжинэ. Энэ зорилтын хүрээнд эрүүл мэндийн салбарын санхүүжилтэд хувийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх, өмчийн хэлбэрийг үл харгалзан эмнэлгүүдийг даатгалын үйлчилгээнд жигд хамруулна.	Эрүүл мэндийн салбарын эрх зүй, санхүүгийн зохицуулалтын механизмыг боловсронгуй болгоно.	2008-2012		
5			Эрүүл мэндийн салбарын төрийн байгууллага болон хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлэх оновчтой механизмыг бүрдүүлнэ.	2008-2012	2009 оны Эрүүл мэндийн Даатгалын санхүүжилтэнд “ Од-чим наран “ хувийн эмнэлгийг хамруулсан. 30256.4 төгрөгний санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгохоор, Улиастай сумын 5 өрх, Тосонцэнгэл сумын 2 өрхийн эмнэлэг, сумын эмнэлгүүдэд эмийн хөнгөлөлттэй үнээр олгох 33417.0 төгрөгний санхүүжилтийг баталж өгсөн.	50
6	1.1.6.3	Эрүүл мэндийн удирдлага, менежмент, эмчилгээний хяналтын тогтолцоог боловсронгуй болгон бэхжүүлнэ.	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын (төрөлжсөн мэргэжлийн, аймаг, дүүрэг, сумын болон өрхийн эмнэлгийн) үйл ажиллагааны стандартыг шинэчилнэ.	2008-2012	Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандартад нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн. Судалгааны ажил хийгдэж байна.	10

7	1.1.7. 5	Хүн ам, ялангуяа өсвөр үе, залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгох арга хэлбэрийг боловсронгуй болгож, хөдөөгийн хүн амд үйлчлэх явуулын эмнэлгийн тогтолцоог бүрдүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг эрт илрүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.	Аймаг бүрт 5-6 сумын дунд явуулын амбулаторийн үйлчилгээг бий болгож, тоноглогдсон тээврийн хэрэгслээр хангана.	2008-2012	Хүн амын эрүүл мэндийг дэмжих тэдэнд эрүүл мэндийн боловсрол олгох, олон нийтэд эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулах зорилтын хүрээнд жил бүрийн үндсэн чиглэлд -“Эхийн эндэгдлийг бууруулах төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж үр дүнг сайжруулах, - Сумдын ард иргэдийг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулна -Вакцинжуулалтаар сэргийлэгддэг халдварт өвчнүүдийг багасгах зорилгоор урьдчилан сэргийлэх тарилганд бүх насны хүүхдийг хамруулж шаардлагатай урвалжаар хангана гэсэн 3 заалтыг оруулж биелэлтийн хүрээнд Баянтэс, Дөрвөлжин, Ургамал, Шилүүстэй, Идэр, Отгон, Их-Уул, Тосонцэнгэл, Эрдэнэхайрхан, Сантмаргац, Цэцэн-Уул сумдын ард иргэдийг нарийг мэргэжлийн эмч нарын үзлэгт 2450 иргэнийг хамруулсан. Мөн энэ жил цас ихээр унаж, үхсэн малын сэг зэм их байгаа учраас халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлж явуулын амбулаторын 2 машиныг төлөвлөгдсөн маршрутын дагуу сумдад ажиллуулахаар боллоо.	30
8	1.1.7. 6		Өрх, сумын эмнэлэг бүрийг нэн шаардлагатай тусламж үйлчилгээний багцад заасан эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүн амд бүрэн үзүүлэх чадавхитай болгох, өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нь түлхүү хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	2008-2012	Баруун бүсийн Өрхийн эмч нарын зөвлөгөөнийг 6 дугаар сарын 19- 21-ны өдрүүдэд Завхан аймагт зохион байгуулж үйл ажиллагаанд зориулж Засаг даргын нөөц сангаас 200.0 / хоёр зуун мянган / төгрөг , Аймгийн Иргэдийн хурлаас 100.0 / зуун мянган / төгрөгийн дэмжлэг үзүүлээ. Хүний томуугийн А хүрээний /H1N1/ вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэхэд зориулж, Улиастай сумын 5, Тосонцэнгэл сумын 2 өрхийн эмнэлгүүдэд тус бүр 100.0 / Зуун мянган төгрөгний тусламжийг үзүүлээ. Өрхийн эмнэлгийн эмч ажилчдад G-mobile-ийн утасний дугаарыг нэмэлт захиалгаар оруулж, холбоо мэдээллийн нөхцлийг сайжруулж хангалт хийлээ. Мөн аймгийн бүх багийн эмч нарт тус бүр нь 100000 төгрөгний үнэтэй эмийн санг хүргүүлээ.	30
9	1.1.7. 7		Сумын эмнэлгийн ариун цэвэр, эрүүл ахуйн стандартыг боловсруулан мөрдүүлж, нөхцлийг сайжруулна.	2008-2012	“Орчны эрүүл мэндийн “ дэд хөтөлбөрийн хүрээнд Дэлхийн зөн ОУ-ийн байгууллагатай хамтран сургалт сурталчилгаа хийж байна. Бүх сумдын эмнэлгүүд эрүүл ахуйн стандартыг мөрдөн ажиллаж байна.	50
10	1.1.7. 8		Багийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд багийн бага эмчийг бэлтгэж, унаатай болгоно.	2008-2012	Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2009 оны үндсэн чиглэлд багийн эмч нарыг унаажуулах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулахаар тусгасан заалтын хүрээнд Тэс суманд-1, Баянтэс-3 Баянхайрхан-2, Асгат-1, Нөмрөг-2, Түдэвтэй-1, Тэлмэн-2, Цэцэн-уул-2 тус тус 8	50

					багийн бага эмчид 3.5/гурван сая таван зуун мянган/ төгрөгийг зарцуулж, 14 морь авч өгч унаажуулсан.	
11	1.1.9.1	Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчнөөс сэргийлэх, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах өнөөгийн тогтолцоог бэхжүүлж, аймаг, дүүргийн түвшинд өргөжүүлнэ.	Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчнийг лабораторийн шинжилгээнд үндэслэн тандах тогтолцоог үндэсний түвшинд бэхжүүлэх арга хэмжээ авна.	2008-2012	Шувууны томуугийн үед авах арга хэмжээний төлөвлөгөө гарган, холбогдох зардлыг тооцон гаргаж төлөвлөсөн. Хүний томуугийн А хүрээний /H1N1/ вирусийн цар тахлын бэлэн байдлыг хангах тухай Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2009 оны 95 тоот тушаалыг гарган хэрэгжүүлж байна. Томуугийн А хүрээний /H1N1/ цар тахлын бэлэн байдлыг ханган ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөөг Томуугийн үед аймгийн хэмжээнд байж болох өвчлөлийн тоо 85836 хүн амд тооцон гаргасан. Бэлэн байдлыг хангах штабын бүрэлдэхүүний үүрэг, дуудан зарлан мэдээлэх схем, голомтонд ажиллах мэргэжлийн багийн бүрэлдэхүүн, Мэргэжлийн багийн гүйцэтгэх үүрэг, Томуугийн үеийн цар тахлын үеийн бэлэн байдлын тооцоог Улиастай сумын 24065 хүн амын 15%, 30%, 50%-ыг хамрах хүрээний үед авах арга хэмжээгээр тооцон төлөвлөгөөг гаргасан . Эрүүл мэндийн салбарын бүх шатны эмнэлгийн гамшиг, онцгой байдлын үе авч хэрэгжүүлэх бэлэн байдлын төлөвлөгөөнд дахин шинэчлэлт хийгдэж байна. Цаашид эрүүл мэндийн салбарын нөөцийг бүрдүүлэх талаар судалгааны ажлыг хийж байна. Томуугийн Үндэсний 5 дугаар зөвлөгөөнд Эрүүл мэнд, Мал эмнэлгийн салбарын 5 төлөөлөгчийг оролцуулсан.	50
12	1.1.9.4		“Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шинэчлэн боловсруулна.	2008-2012	“Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт үнэлгээг хийж, аймгийн Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн хурлаар тайланг хэлэлцүүлээ. Үнэлгээний дүнд үндэслэн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд шаардлагатай зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлж байна.	50
13	1.1.1 1.2	Хүн амын эрүүл мэндийн мэдээллийн цахим сан байгуулна. Эмнэлгийн цахим сүлжээ, алсын зайн оношлогоо, эмчилгээг өргөжүүлэн, иргэн бүрт эрүүл мэндийн үйлчилгээг шаардлагатай түвшинд үзүүлэх бололцоог хангах зорилгоор анагаах ухааны орчин үеийн ололтод тулгуурласан төрөлжсөн мэргэжлийн төвүүдийг	Алсын зайн оношлогооны сүлжээг өргөжүүлж, бүх аймгийн нэгдсэн эмнэлгийг хамруулна.	2011-2012	Аймгийн нэгдсэн эмнэлэгт “Зайн оношлогооны төв”-ийг байгуулж 5 дугаар сарын 8 нд нээн ажиллуулж эхэллээ. Энэ нь хөдөө орон нутагт анх байгуулагдснаараа онцлог төдийгүй иргэд хот явж өндөр зардал гаргахгүй, цаг алдалгүй оношлогдож хүндрэлээс сэргийлэх боломжтой боллоо. Энэ төвийн тоног төхөөрөмжийг авахад аймгийн Эрчимтэй хөгжлийн сангаас 40.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн .	100

		хөгжүүлж, өвчнийг эрт оношлох, эмчлэх, нөхөн сэргээх чадавхийг дээшлүүлнэ.				
14	1.1.1 3.2	“Эрүүл эхээс эрүүл хүүхэд” зарчмыг эмнэлгийн тусламж, үйлчилгээний бүх шатанд хэрэгжүүлж, эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийг тууштай бууруулна.	Аймгийн нэгдсэн эмнэлгийн дэргэдэх төрөх, хүүхдийн тасгийн тоног төхөөрөмжийг сайжруулж, хэрэгцээг харгалзан шаардлагатай тохиолдолд төрөх газар болон хүүхдийн эмнэлгийг шинээр барьж, перинатологийн төв байгуулна.	2008-2012	Дэлхийн зөн ОУ-ийн байгууллагын “Завханхангай” ОНХХ, ЭМГ хамтран “Эх хүүхдийн хоол тэжээл” төслийг Канад улсын хөрөнгө оруулалттай 2 жил, “Эх хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулах нь” төслийг Австрали улсын хөрөнгө оруулалттай Дэлхийн зөн ОУ-ийн байгууллагын “Завхан” ОНХХ 3 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр 5 дугаар сараас эхлэн үйл ажиллагаагаа явуулж байна. Төслийн хүрээнд Сумын Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн дарга, эмч, Нийгмийн эрүүл мэндийн арга зүйч, эх баригч бага эмч нарыг оролцуулан 150 хүний сургалтыг явууллаа. “Эх хүүхдийн хоол тэжээл, хяналтыг сайжруулж эндэгдлийг бууруулья” сэдэвт зөвлөгөөнийг хийлээ. Эх хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор зарим сумын эмнэлэгүүдийн төрөх тасагт засвар хийж, тоног төхөөрөмжөөр хангасан ба усан хангамжийг сайжруулах ажил хийлээ.	30
15	1.1.1 9.1	Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлогыг тодорхойлж, удирдлага зохион байгуулалт, судалгаа, шинжилгээ, эдийн засаг, санхүүгийн механизмыг боловсронгуй болгоно.	“Биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлого”-ыг боловсруулж, биеийн тамир, спортын эрчимтэй хөгжлийг хангах эрх зүйн удирдлага зохион байгуулалт, санхүүжилтийн эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.	2008-2012	Засгийн газрын 2009 оны 05 дугаар тогтоолыг хэрэгжүүлж зорилтын хүрээнд сар бүр байгууллагууд спортын арга хэмжээнүүдийг зохион байгуулж байна. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2009 оны Үндсэн чиглэлд тусгагдсан заалтыг хэрэгжүүлж 5 дугаар сарын 29-31 ны өдрүүдэд “Хаврын баяр-2009” спортын 7 төрлөөр наадмыг зохион байгуулж Засаг даргын нөөц сангаас 3.0/ гурван сая / төгрөгийг зарцуулсан.	50
16	1.1.1 9.2		Биеийн тамир, спортоор хичээллэхийн ач холбогдлыг сурталчлах мэдээлэл, сурталчилгааны ажлыг нэгдмэл байдлаар зохион байгуулна.	2008-2012	Биеийн тамир, спортоор хичээллэхийн ач холбогдлыг оюутан сурагч, иргэдэд сурталчилан таниулах зорилгоор орон нутгийн “Завхан”, “Этүгэн” телевизүүдтэй хамтран ажиллаж аймгийн хэмжээнд зохион байгуулж байгаа спортын уралдаан тэмцээнүүдийг нэвтрүүлж байна. Мөн эрүүл мэндийн газраас “Спорт бидний эрүүл мэндэд” захиалгат нэвтрүүлгийг бэлтгэн дээрх телевизүүдээр нэвтрүүлж нийтэд сурталчиллаа.	30
17	1.1.1 9.3		Нийтийн биеийн тамир, спортын байгууллагын барилга байгууламжийн засвар үйлчилгээ, ашиглалтыг үе шаттай сайжруулна.	2008-2012	Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд засвар үйлчилгээний ажлыг тусган арга хэмжээг хэрэгжүүлж ирлээ. 2009 оны үндсэн чиглэлд Биеийн тамир спортын газрын барилгын өргөтгөлийн ажлыг тусган оруулж, 250.000 /хоёр зуун тавин сая / төгрөгийн хөрөнгөөр Эрдэнэт хотын Мөнхцоож захиралтай “БЯ-ЦО” ХХК гүйцэтгэж ашиглалтанд өгсөн. Нээлтийн үйл ажиллагааг 10 дугаар сарын 17-ны өдөр	50

					хийж, Аймгийн удирдлагууд, “Олимп-эв” нэгдэл багийнхан оролцсон. -Улиастай сумын Засаг даргын Тамгын газраас арван сая /10.0/ төгрөгийн санхүүжилтээр Аймгийн баяр наадмын “Цэнгэлдэх хүрээлэн” -гийн засварын ажлыг хийж гүйцэтгэсэн. Эрдэнэхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн дэргэд биеийн тамирын заалыг улсын төсвөөс зуун наян сая төгрөгийн санхүүжилтээр баригдаж 2009 оны 9 дүгээр сард барилгын ажлыг гүйцэтгэж ашиглалтанд өгсөн.	
18	1.1.2 0.3	БЗДХ, ХДХВ, ДОХ-ын эрсдэлээс урьдчилан сэргийлж, ХДХВ-ийн халдвар, ДОХ-ын тархалтыг өнөөгийн түвшинд тогтоон барина.	Хяналт-шинжилгээ, судалгааны үр дүн, нотолгоог ХДХВ/ДОХ/БЗДХ-ын эсрэг хариу арга хэмжээ төлөвлөх, шийдвэр гаргахад үр дүнтэй ашиглана.	2008-2012	Аймгийн Засаг даргын 2009 оны 97 тоот захирамжаар ХДХВ/ДОХ-оос сэргийлэх үйл ажиллагааг зохицуулах аймгийн салбар зөвлөлийг байгуулан үйл ажиллагааг явуулж байна. Аймгийн хэмжээнд эрсдэлт бүлгийн дунд судалгааг хийж, үйлчилгээний газрын менежер, ажилчдад сургалтыг зохион байгуулж, мэдээлэл сургалт сурталчилгааны материал, бэлгэвч байрлууллаа. Завхан телевиз ,Этүгэн FM зэрэг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчилгааг тогтмол явуулж байна. Дэлхийн зөн Олон улсын байгууллагатай хамтран ДОХ-ыг хэн сайн мэдэх вэ? сэдэвт Дэвжээ тэмцээн оюутнуудын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулж байна. -Сургуулиуд дээр “Хамтдаа сэргийлье” сурталчилгааны танхим байгуулагдсан тогтмол үйл ажиллагаа явуулж байна. -Эхийн эндэгдлийг бууруулах, ХДХВ/ДОХ/БЗДХ-ийг жирэмсэн эмэгтэйн хяналттай интегрчлах нь, Глобаль сан төслийн хүрээнд эмч мэргэжилтнийг сургалтанд хамруулсан. Энэ төслүүдийн хүрээнд сумдад лаборант, бэлтгэсэн багаж тоног төхөөрөмжөөр хангасан.	50
Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилт						43
1.2 Боловсрол соёл шинжлэх ухааны бодлого						
19	1.2.2. 1	Баг бүрт гэр цэцэрлэг байгуулах, хувилбарт сургалтын төрөл хэлбэрийг олшруулах замаар сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 2012 он гэхэд 70 хувьд хүргэнэ.	Баг бүрт гэр цэцэрлэг байгуулж, хувийн хэвшлийн цэцэрлэг байгуулахыг дэмжин сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлнэ.	2009-2012	Аймгийн хэмжээнд СӨБ-ын насны 5382 хүүхэд байгаагийн 3488 нь цэцэрлэгт хамрагдаж 64.8 хувь , сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг малчдад ойртуулах зорилгоор ээлжийн бүлэг, нүүдлийн бүлэг, гэр цэцэрлэг ажиллуулах замаар 1060 хүүхдийг хамруулснаар СӨБ-ын хамран сургалт 84.5 хувьтай байна. 2009 онд Их-Уул, Идэр, Алдархаан, Яруу сумын хүүхдийн цэцэрлэгүүдэд “Үр дүнд түргэн хүрэх санаачлагын түншлэл” хөтөлбөрийн хүрээнд иж бүрэн хэрэглэл бүхий тус бүр 2 гэр нийлүүлээд байна.	50

20	1.2.2. 2		Өмчийн хэлбэр үл харгалзан цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох нормативт зардлыг олгоно.	2008-2012	Завхан аймагт төрийн өмчийн 32, хувийн хэвшлийн 2 нийт 34 цэцэрлэгт хамрагдаж буй 3488 хүүхдэд ноогдох хувьсах зардлыг бүрэн олгож үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байна.	50
21	1.2.2. 4		Цэцэрлэгийг тоглоом наадгай, тоног төхөөрөмжөөр хангаж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.	2010-2012	Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор хүн ам төвлөрсөн Улиастай сумын Жаргалант багт шинээр баригдсан цэцэрлэгт гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлэх асуудал шийдвэрлэгдлээ. ДЗОУБ, Тогтвортой амьжиргаа төслийн хүрээнд 5 цэцэрлэгт 34,5 сая төгрөгийн тоглоом наадгай нийлүүлсэн байна.	70
22	1.2.2. 5		Цэцэрлэгийн барилга барих, өргөтгөх, засварлах замаар хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	2009-2012	Улиастай сумын Жаргалант багт 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг шинээр барьж ашиглалтанд орууллаа. Чигэстэй баг, Тосонцэнгэл хотод тус бүр 100 хүүхдийн , Яруу суманд цэцэрлэгийн барилга барих асуудлыг судалж байна.	30
23	1.2.3. 5	Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлж, боловсролын хүртээмж, чанарыг дээшлүүлнэ.	Бага боловсролын хамран сургалтыг 95.0 хувьд хүргэнэ.	2009-2012	Цогцолбор болон бүсийн түшиц сургуулийг түлхүү дэмжих чиглэл баримтлан Шилүүстэй, Завханмандал, Сантмаргац сумдын сургуулийн хичээлийн болон дотуур байранд иж бүрэн засвар хийж, Их-Уул, Тосонцэнгэл, Түдэвтэй сумдад хичээлийн байр шинээр барьж байна. ЕБС-ийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулж,6 настай хүүхдийг сургуульд бүрэн хамруулж, сургууль завсардалтыг зогсоосноор суурь боловсролын хамран сургалтыг 98.0 хувьд хүргэсэн байна.	100
24	1.2.4. 5	Ерөнхий боловсролын сургуулийг мэргэжлийн багшаар бүрэн хангаж, тэдний мэргэшлийг дээшлүүлнэ.	Багшийн мэргэжлийн үнэлэмж, нэр хүндийг дээшлүүлж, багш, боловсролын байгууллагын удирдах ажилтны цалин, хангамжийг нэмэгдүүлнэ.	2009-2012	Багшийн мэргэжлийн үнэлэмж, нэр хүндийг дээшлүүлэх зорилгоор сургалтын чанарыг сайжруулах 3 жилийн аяныг зохион байгуулж байна. Энэ хүрээнд “ Би хөгжсөн багш мөн үү?”, “Би хөгжиж байгаа багш уу?” ,”Би хөгжөөгүй багш уу?” сэдвээр нийт багш нарын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж багш бүр өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна. Сургуулийн удирдах ажилтан, багш нарт сургалтын ажлын үр дүнгээр цалин урамшил олгож байгаа нь сургалтын чанар, багшийн мэргэжлийн нэр хүнд үнэлэмжийг дээшлүүлэхэд чухал хөшүүрэг болж байна.	50
25	1.2.4. 6		Багш, ажилтнууд сургууль дээрээ мэргэшил дээшлүүлэх, бүтээлчээр ажиллах нөхцөл бүрдүүлэхэд шаардлагатай орчны стандарт боловсруулж, төрийн өмчийн бүх сургуулийн багш нарын өрөө, ажлын байрыг стандартын шаардлагын дагуу тоноглоно.	2009-2012	Багш нарын мэргэжил дээшлүүлэх талаар СӨБ, ЕБС-ийн нийт 1016 багшийг багшийн ёс зүй, эрүүл мэндийн хичээлийн технологи, байгаль орчны боловсрол, үнэлгээний мэргэжлийн шинжээч багш бэлтгэх, хүүхдэд ээлтэй сургуулийн орон нутгийн сургагч багш бэлтгэх, албан бус боловсролын багш бэлтгэх, 6 настай хүүхдэд хичээл заах багш бэлтгэх, шилжилтийн 7-р ангид хичээл заах багш бэлтгэх зэрэг сургалтанд хамрууллаа.	50

					Мөн БСГ-ын сургалтын танхим байгуулж тохижуулах асуудлыг БСГ-ын хуучин байрыг ашиглан хийж байна. Уг барилгыг “Багшийн хөгжлийн төв” болгох зорилгоор Сургалтын танхимыг нь тохижуулан “ВЭБ” сайт нээн зайн сургалтын танхимыг өргөжүүлэн цахим самбар, проектортой болгов. Номын санг өргөжүүлэн 426,1 мянган төгрөгийн 59 ширхэг номоор номын фондоо баяжууллаа. ЕБС-иуд багш нарын өрөөтэй болж багш ажлын байрандаа мэргэжил боловсролоо дээшлүүлэх нөхцлийг бүрдүүлж байна.	
26	1.2.5.1	Бичиг, үсэг тайлагдалтын түвшинг ахиулна.	Хүн амын бичиг үсэг тайлагдалтын түвшинг нэмэгдүүлнэ.	2009-2012	Бичигтэн 2009 сургалтанд бичиг үсэг үл мэдэгч 321 хүн хамрагдаж, 251 суралцагч бичиг үсэг тайлагдсан байна.	30
			Ерөнхий боловсролын сургуулиас завсардсан сурагчдад албан бус боловсрол, дүйцсэн хөтөлбөрийн сургалтаар боловсрол нөхөн олгоно.	2009-2012	Сум бүрт Албан бус боловсролын Гэгээрлийн төвүүдэд 24 арга зүйч багш ажиллан 2009 онд сургуулийн гадна байгаа сургуулийн насны 246 хүүхдийг дүйцсэн хөтөлбөрийн сургалтанд хамруулж боловсрол нөхөн олгосноос 52 суралцагч боловсролын гэрчилгээ авсан байна.	50
27	1.2.6.3	Төрөөс ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг сурах бичгээр хангана.	Төрөөс ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг сурах бичгээр хангах график төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулна.	2009-2012	Ерөнхий боловсролын сургуулийн 1,2-р ангийн сурах бичгийг төрөөс бүрэн хариуцаж 2663 сурах бичгийг сургуулиудад хүргэсэн байна. Сургуулиудад хүргэгдсэн 3,4,5-р ангийн сурах бичиг нь нийт сурагчдын 40%-ийг хангаж байгаа юм. 2009-2010 оны хичээлийн жилд шинээр 19 төрлийн 19039 сурах бичгийг нийлүүлээд байна.	30
28	1.2.7.1	“Үдийн цай” хөтөлбөрийг үргэлжлүүлж, “Үдийн хоол” хөтөлбөр болгон өргөжүүлнэ.	Үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан сургуулийн хоолны газар, дотуур байрны гал тогоог зориулалтын тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулна.	2009-2012	2009 онд Сантмаргац, Тэс, Шилүүстэй сумдын дотуур байранд засвар хийж,Улиастайн IY, Эрдэнэхайрхан, Их-Уул, Цэцэн-уул, Сантмаргац ,Сонгино сумдын сургууль шинээр “Үдийн цай-хоолны цех” тэй болсон байна. Хичээлийн 5 өдрийн 2 өдөрт нь халуун хоолоор үйлчилж эхэлснээр Үдийн цайг Үдийн хоол болгох эхлэл тавигдлаа.	50
29	1.2.7.2		“Үдийн хоол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам батлан мөрдүүлж, сурагчдыг хөтөлбөрт ээлж дараатай хамруулна.	2010-2012	Үдийн цай хөтөлбөрт 1-5-р ангийн 8516 хүүхэд хамрагдаж, 436.2 төгрөгний санхүүжилт хийгдээд байна. Үдийн цайг үдийн хоол болгох эхлэлийг тавьж 7 хоногийн хичээлийн 5 өдрийн 2 өдөрт нь халуун хоол өгч байна. Үдийн цай хоолны амт, чанар, хүрэлцээ сайжирч нэр төрөл нь олширлоо. 6-11 дүгээр ангийн сурагчдад чацаргана, нэрс, анисны сок, аарц, халуун цай өгч байгаа нь эцэг эх, сурагчдын сайшаалыг хүлээж байна.	50
30	1.2.9.1	Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн ээлжийн коэффициентийг бууруулж, сурагчдын дотуур байрны хүрэлцээг нэмэгдүүлнэ.	Ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар ээлжгүй болгоход чиглэсэн арга хэмжээ авна.	2009-2012	Тосонцэнгэл сумын I сургуульд 640 хүүхдийн, Түдэвтэй,Их-Уул суманд тус бүр 320 хүүхдийн суудалтай хичээлийн барьж эхлээд байна. Эрдэнэхайрхан сумын спорт заалны барилгын дуусгал, Сантмаргац, Идэр,Нөмрөг, Яруу сумдын хичээлийн байр,спорт заалны засварт нийт 829,9 сая төгрөгийн засварын ажил хийгдэж ашиглалтанд орууллаа.	30

					Аймгийн хэмжээнд 3 ээлжээр хичээллэж байгаа сургууль байхгүй байна.	
31	1.2.9.3		Ангийн самбар, тавилга, сурагч, багшийн ширээ, сандлыг ээлж дараатай шинэчилнэ.	2009-2012	ЕБС-ийн 6 настай хүүхдийн болон багшийн ширээ сандал, самбар, хичээлийн хэрэглэлийн тавиур, ус буцалгагч зэрэг 19,8 сая төгрөгний тавилга тоног төхөөрөмж мөн 80 бүлэгт 54,3 сая төгрөгний тоглоом бүгд 74,1 сая төгрөгний хөрөнгө оруулалт хийгдэж сургалтын орчин сайжирлаа. Эхний ээлжинд бүсийн түшиц сургуулиудад биеийн тамир спортын хэрэглэл материал нийлүүлэх чиглэл баримталснаар 2009 онд Чандмань-Эрдэнэ, Жавхлант цогцолбор сургуулиудад 44 төрлийн 11,1 сая төгрөгийн биеийн тамир спортын хэрэглэл материал нийлүүлээд байна.	50
32	1.2.9.4		Дотуур байр барьж, өргөтгөн, дотуур байрны орчин, ариун цэвэр, усны хангамжийг сайжруулна.	2009-2012	ЕБС-ийн 32 дотуур байранд 2538 хүүхэдамьдарч байна. Бүх дотуур байрыг цайны газар, номын сан, эрүүл мэндийн өрөө, угаалгын газартай болгон тохижуулснаар хүүхдийн амьдрах орчин сайжирч байна. 2009 онд Сантмаргац, Шилүүстэй, Идэр сумдын дотуур байранд их засвар хийсэн байна.	30
33	1.2.1 0.1	Аймгийн төвүүдэд усан бассейн байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын хичээлийн хөтөлбөрт усанд сэлэлтийн төрлийг оруулна.	Зарим аймгийн төвд усан бассейн байгуулж хүүхэд, залуучуудын биеийн тамир, спортоор хичээллэх орчин бүрдүүлнэ.	2010-2012	Хүүхэд залуучуудын ордныг түшиглэн хүүхэд залуучуудын чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэхэд чиглэсэн 11 дугуйлан хичээллүүлж байна. Усан бассейн, амралт чөлөөт цагийн төв байгуулахаар холбогдох судалгаа хийж, холбогдох газруудад албан тоот хүргүүлээд байна.	30
34	1.2.1 2.2	Мэргэжлийн боловсрол сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийг орчин үеийн сургалтын бааз, лабораториор хангаж, технологийн шинэчлэл хийнэ.	Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг сайжруулж, эрэлт, нийлүүлэлтэд тохирсон мэргэжилтэй ажилтан бэлтгэх төлөвлөлтийг сайжруулна.	2009-2012	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгааг хийхэд Завхан аймагт техник технологийн чиглэлийн мэргэжилтэн дутагдалтай байгаа юм. МСҮТ-ийн сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг түүнтэй уялдуулан зохицуулж, гутал гутал засвар, Монгол дарханы ангийг хааж, шинээр жижиг дунд үйлдвэрийн цахилгаанчин, электроникийн засварчны ангийг нээн хичээллүүлж байна. Цаашид Тосонцэнгэлд МСҮТ-ийн салбар байгуулж жимс жимсгэнэ, ойн нөхөн сэргээлт, ХАА-н машин механизмын засварчны ангийг хичээллүүлэхээр төлөвлөж байна.	50
35	1.2.1 4.3	Инженер технологи, байгалийн шинжлэл, багш, эмч, хөдөө аж ахуйн мэргэжлээр суралцагчдын хувийн жинг нэмэгдүүлнэ. Сургалтын төрийн сангаас үзүүлж буй зээл,	Дотоодын их, дээд сургуульд суралцахаар зохих журмын дагуу элсэж, сумын ИТХ-ын Тэргүүлэгчид, Засаг даргын захиалгаар албан ёсны гэрээ байгуулсан оюутны сургалтын зардлыг төрөөс хариуцна.	2009-2012	2009-2010 онд Төрийн албан хаагчдын гэр бүлээс нийт 652 оюутан суралцаж, сургалтын төлбөрийг төрөөс бүрэн санхүүжүүлж байна. Хөдөө орон нутагт эмч дутагдалтай байгаатай холбогдуулан 15 оюутны сургалтын төлбөрийг орон нутгаас хариуцан ЭМШУИС, Монос, Ач дээд сургуулиудад төгсөөд орон нутагтаа ажиллах нөхцөлтэйгөөр сургаж байна.	30

		тусламжийг газраас мэргэжлийн сурлагын дэмжих, нутгийг мэргэжилтнээр, дотор багш, техникийн болон хангахад Засгийн тогтоосон чиглэл, амжилтыг алслагдмал хэрэгцээтэй түүний инженер, хүний эмчээр чиглүүлнэ.				
36	1.2.2 0.1	Их, дээд сургууль, мэргэжлийн төрөлжсөн сургууль болон тэдгээрийн салбарыг бүсийн төв болон орон нутгийн хотод байгуулахыг дэмжинэ.	Бүсийн төвүүдэд үйл ажиллагаа явуулж байгаа дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагыг төрөөс дэмжинэ.	2010-2012	МУИС-ийн ЭЗсС үндсэн 6 мэргэжилээр мэргэжилтэн бэлтгэж, өдрийн ангид 694 оюутан суралцаж байна. Бүс нутгийн онцлог эрэлт хэрэгцээнд нийцүүлэн Аялал жуулчлалын менежмент, Татварын нябо хяналтын ангийг, МСҮТ Компьютер электроникийн засварчны ангийг шинээр нээн хичээллүүлж байна. МСҮТ баруун бүсийн барилгын өргөн мэргэжилтэн бэлтгэх түшиц сургууль болон өргөжих юм. 2009 онд тус сургуульд АХБ-ны БХХ-ийн хүрээнд Барилга, автомеханикийн иж бүрэн тоног төхөөрөмж, компьютерийн лаборатори нийлүүлээд байна. МСҮТ-ийг өргөтгөн Тосонцэнгэлд салбар байгуулж, ойн нөхөн сэргээлт, жимс жимсгэнэ, ХАА-н машин механизмын засварын анги нээхээр төлөвлөн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, дадлагын газарт шаардагдах тоног төхөөрөмжийн тооцоо судалгааг гаргаж холбогдох яамдад хүргүүлээд байна. СУИС-ийн харъяа ХБК –ийн хичээлийн байрны өргөтгөлийг шинээр барьж баруун бүсийн соёл урлагийн мэргэжилтэн бэлтгэх, мэргэжлийг дээшлүүлэх түшиц сургууль болгон өргөжүүлэх чиглэлээр ажиллаж байна. Тус сургууль дээр 2009 онд Увс, Говь-Алтай аймгаас 5 хүн хөгжмийн зохиолч, хөгжмийн удирдаачаар мэргэжил дээшлүүлсэн байна.	50
37	1.2.2 5.1	Сумын соёлын төвийн үйл ажиллагааны агуулга, хэлбэрийг баяжуулж тогтмолжуулах, соёлын төвүүдийн барилгыг шинэчилж засварлах, хөгжмийн зэмсэг, ном, тоног төхөөрөмжөөр хангах замаар хүүхэд, залуучууд, хүн амд хүргэх соёлын үйлчилгээний үр	Соёлын төвүүдийн барилгыг шинээр барих, их засвар хийх ажлыг дэс дараатай хэрэгжүүлнэ.	2009-2012	2009 онд Их-Уул, Отгон, Эрдэнэхайрхан сумдын соёлын төвүүдийн засварт төсвөөс 10.9 сая, төсөл хөтөлбөрийн хүрээнд 50.4 сая төгрөгийн сандал, гэрэлтүүлэг, техник хэрэгсэл нийлүүлсэн байна. Их-Уул, Тосонцэнгэл, Идэр,Тэс, Ургамал, Цагаанхайрхан, Отгон, Яруу сумдад хөгжмийн зэмсэг, техник хэрэгсэл олголоо. Тэлмэн, Дөрвөлжин сумдын соёлын төвийн барилгын талаар мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт гарч шинэ барилга бариулах асуудлыг судалж байна.	30

		өгөөжийг дээшлүүлнэ.				
38	1.2.2 5.3		Хөдөө орон нутгийн алслагдсан хүн амыг мэдээллээр хангах хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлж, “Явуулын номын сан”-гийн үйлчилгээг нэвтрүүлнэ.	2008-2012	2009 онд бүх сум, сургуулийн номын санд Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл дор хэвлэгдсэн Гадаадын уран зохиолын 20 боть, Гэсэр, Жангар, Нууц товчоо, Азийн сан, Японы тусламжаар нийлүүлсэн нийт 61,6 сая төгрөгийн үнэ бүхий 8188 ширхэг номоор баяжуулаад байна. Сумдын номын сангууд явуулын үйлчилгээгээр хөдөөгийн малчдад номын үйлчилгээг хүргэж байна.	30
39	1.2.2 8.3	Монгол Улсын түүх судлалыг хөгжүүлж, Монгол Улсыг сурталчлах үйл ажиллагааг өргөжүүлнэ.	Үндэсний түүх, нүүдлийн соёлоо судлан сурталчлах, монгол бичгээ өвлүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлж, “Монгол бичиг”, “Морин хуур, уртын дуу”, “Монгол хөөмий”, “Монгол бий, биелгээ”, “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах” хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	2008-2012	Үндэсний бичиг соёлоо дээдлэн хөгжүүлэх талаар анхаарч Монгол Улсын Гавяат багш Ж.Алтангэрэл, АБТА Л.Лхагважав нарын нэрэмжит Эх хэлний олимпиадыг жил бүр уламжлал болгон Улиастай, Идэр сумдад зохион байгуулж хэвшээд байна. 2009 онд 15 сургуулийн 68 багш, 389 суралцагч оролцлоо. Ардын уламжлалт соёл урагийг хөгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай аймгийн Засаг даргын 2009 оны 69 дүгээр захирамж гарган хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд аймаг, сумдын Засаг даргын дэргэд Морин хуурын чуулга, хамтлагууд байгуулж, шаталсан сургалтуудыг зохион байгуулснаар 200 хүүхэд шинээр морин хуур сурч, тэднийг хөгжим, тоглолтын хувцастай болгох асуудлыг шийдвэрлэлээ. МАЯУХ-той хамтарч дэлхий бүжгийн өдрийг Улиастай хотод зохион байгуулж, 500 –гаад бүжигчид, биелээчид оролцов. Ардын болон орчин үеийн бүжгийн дугуйлан тогтмол хичээллүүлж 70 гаруй хүүхдийг хамруулаад байна.	50
Боловсрол соёл шинжлэх ухааны бодлогын хэрэгжилт						47,1
1.3 Хөдөлмөрийн зах зээл хөдөлмөр эрхлэлтийн бодлого						
40	1.3.1. 2	Ажлын байр, ажил эрхлэлтийг нэмэгдүүлж, иргэдийн идэвх, санаачилгыг дэмжин бизнес эрхлэх орчныг бүрдүүлэх, хүн бүрийг эдийн засгийн идэвхтэй, хөдөлмөрийн чадвартай байлгахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж, ядуурлыг бууруулна.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх бодлогыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санаачилгад тулгуурлан орон нутаг, бүсийн хөгжил, салбарын бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.	2009-2012	Тосонцэнгэл, Их-уул сумдад 5 сарын 5-7 ны өдрүүдэд Тэс суманд 10 сард тус тус ажил олгогчдын зөвлөгөөн, хөдөлмөрийн биржийг зохион байгуулж, 30 цагийн шинэ-эхлэл сургалтыг явуулж 450,0 мянган төгрөг зарцуулсан. Мөн 1413 иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан. Ажил хайгч 1798 хүнд хөдөлмөр эрхлэлтийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч ХЭДСангаас 11100,1 мянган төгрөгийг зарцуулсан. Ажил идэвхитэй хайж байгаа 450 иргэнийг хөдөлмөрийн зах зээлийн менежер программд бүртгэл хийсэн.	50
41	1.3.6. 2	Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг өрхийн хэрэгцээтэй уялдуулж, өрхийн нэгээс доошгүй хүнийг ажилтай болгох	“Нэг өрх - нэгээс доошгүй ажлын байр” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	2009-2012	Ажил идэвхитэй хайж байгаа болон сургалтанд хамрагдах сонирхолтой нийт 3500 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсний зэрэгцээ 1888 иргэнийг шинээр бүртгэн интернетэд байршуулаад байна. Мөн 928 иргэнийг байнгын ажлын байранд зуучлан ажиллуулж байна.	30

		замаар жилд 60,0 мянгаас дээш ажлын байр бий болгоно.			Энэхүү хөтөлбөрт 20 өрхийг хамруулж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэхэд нь зориулж 40000.0 мянган төгрөгийг зарцуулсан.	
42	1.3.7.1	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцагчдын тоог нэмэгдүүлэх, аж ахуйн нэгж, үйлдвэрийн газрыг түшиглэсэн түргэвчилсэн сургалтаар мэргэжил олгох тогтолцоог урамшуулан дэмжиж, мэргэжлийн зөрүүгээс ажилгүйдэл үүсэх шалтгааныг бууруулна.	Эрэлтэд тулгуурласан “Эрхийн бичиг”-ийн сургалтыг орон нутагт өргөжүүлнэ.	2009-2012	2009 оны байдлаар 14 мэргэжлийн сургалтын байгууллагатай хамтран 18 төрлийн мэргэжлээр түр сургалт зохион байгуулан явууллаа. Мэргэжил олгох түр сургалтыг 16 суманд зохион байгуулсан. Тосонцэнгэл сумын зам барилгын АЗЗА компани дээр үйлдвэр дээрх сургалтанд 20 хүн хамруулсан байна. Мөн бизнесийн ур чадвар олгох, төсөл хөтөлбөр боловсруулах сургалтыг Бизнес инкубатор төв болон бусад сургалтын байгууллагуудтай хамтран 6 төрлөөр явуулж нийт 225 хүн хамруулснаас тэдний 40 гаруй хувь нь жижиг зээлийн үйлчилгээнд хамрагдаж хувиараа хөдөлмөр эрхэлж байна. Түүнчлэн аймгийн МСҮТ-ийг улсын хэмжээний загвар сургууль болгон өргөтгөж Тосонцэнгэл суманд МСҮТ байгуулахаар төлөвлөн бэлтгэл ажлаа хангасан.	50
43	1.3.1.5.1	Өрх бүрээс мэргэжлийн сургалтад хамрагдах хүсэлтээ илэрхийлсэн нэгээс доошгүй хүнийг мэргэжил эзэмшүүлж, ажилтай болгоно.	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв болон техникийн боловсролын сургуульд суралцагчдын тоог гурав дахин нэмэгдүүлнэ.	2009-2012	Мэргэжил олгох сургалтанд хамрагдах сонирхолтой нийт 1068 хүний өргөдөл материалыг хүлээн авч мэргэжил олгох сургалтанд 765 хүн, давтан сургалтанд 58 хүн, зөвөлгөө өгөх төсөл хөтөлбөр боловсруулах сургалтанд 225 хүн хамрууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй 21 хүнийг мөн сургалтанд хамруулж 1.3 сая төгрөг зарцууллаа.	30
Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилт						40
1.4 Нийгэм хамгааллын бодлого						
44	1.4.1.1	Нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, төрөл, хэлбэрийг оновчтой болгоно.	Нийгмийн ажилтнуудыг мэргэшүүлэх, тэдний ёс зүйн хэм хэмжээг тогтоон мөрдүүлэх арга хэмжээ авна.	2009-2012	Сумдын хөдөлмөр халамжийн үйлчилгээний мэргэжилтнүүдийн хөдөлмөр эрхлэлт болон шинээр нэвтэрч буй халамжийн үйлчилгээний менежер программын ашиглалтын талаар сургалт зохион байгуулсан. Байгууллагын мэргэжилтнүүдийн компьютерийг засварлаж дотоод сүлжээнд холбогдсон. Сумдын нийгмийн ажилтнуудад Хяналт шинжилгээ үнэлгээ хийх журам, 2009 онд хийгдэх хяналт шалгалтын ажлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл хийж, сургалт зохион байгууллаа.	30
45	1.4.6.1	Халамжийн үйлчилгээний зохион байгуулалт, менежментийг сайжруулж, түүнд хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудыг татан оролцуулах бодлого баримтална.	Нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэж буй төв болон орон нутгийн байгууллагуудын ажил үүргийн зохион байгуулалтыг сайжруулж, нийгмийн хамгааллын үйлчилгээг хүнд сурталгүй, ил тод, шуурхай болгох арга хэмжээ авна.	2009-2012	Аймгийн 24 суманд хөдөлмөр халамжийн мэргэжилтэн томилон ажиллуулж байна. Тосонцэнгэл, Их-Уул сумдын ажил олгогч нарт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн болон хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн талаар сургалт семинар хийж тэднийг цаашид үйл ажиллагаа явуулахад нь хэрэгтэй мэдээллээр хангаж ажиллаж байна. ХХҮХ нь энэ оноос Хяналт-шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн ажиллуулах болсон.	30
46	1.4.1	Амьжиргааны түвшинг	“Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний	2009-2012	2010 ЭЗС-ийн социалогийн тэнхимтэй хамтран ядуурлын	10

	1.2	тодорхойлох аргачлалыг боловсронгуй болгож, ядуурлын зураглал гарган нийгмийн хамгааллын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сантай болно.	хөтөлбөр"-т үндэслэн бүс нутгийн болон эдийн засаг, дэд бүтцийн хөгжилтэй уялдсан арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.		зураглал гарган, аймгийн хэмжээнд ядуурлын судалгаа хийхээр төлөвлөн ажиллаж байна.	
47	1.4.1 2.1	Өрхийн хэрэгцээ, чадавхи, санаачилгыг дэмжих “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулан хэрэгжүүлэх замаар 50000-аас доошгүй ядуу өрхийн амьжиргааг дээшлүүлнэ.	Хувийн хэвшил, иргэдийн оролцоо, санаачилгад тулгуурлан “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.	2009-2012	Өрхийн хөгжлийн дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж аймгийн хэмжээнд ядуурлаас гаргах 398 өрхийг өрхийн хөгжлийн төлөвлөгөөтэй болгосон. Үүнээс 258 өрх нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, нийгмийн халамжийн арга хэмжээнд бүрэн хамрагдаж тэдний амьдралд нилээд өөрчлөлт гарч байна. 398 өрхийн 1000 орчим гишүүдээс давхардсан тоогоор 600 орчим нь орлогын ямар нэг эх үүсвэр олох буюу олж болох арга хэмжээнд хамрагджээ. Энэхүү хөтөлбөрт нийт 158537,7 мянган төгрөгийг зарцууллаа.	50
48	1.4.1 2.2		“Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-т хамрагдах өрхийг сонгох, өрхийн хөгжлийн төлөвлөгөө гаргах аргачлалыг боловсруулна.	2009-2012	Хөтөлбөрт хамрагдах 398 өрхийг 24 сумдад хүн ам, өрхийн тоог үндэслэн Улиастай 70 өрх, Тосонцэнгэл 35 өрх, Их-Уул 21 өрх, бусад сумдад 3-9 өрх хуваарилагдсан. Өрхийн мэдээллийг өрхийн хөгжлийн төлөвлөгөөний дагуу гаргаж, аймгийн ХХҮХ дээр мэдээллийн санг бүрдүүлсэн.	50
49	1.4.1 23		Өрхийн хөгжлийн төлөвлөгөөнд үндэслэн тухайн өрхийг хөгжүүлэх, амьжиргааг дээшлүүлэх ажлыг хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоотойгоор зохион байгуулж, хөтөлбөрт хамрагдсан өрхийн мэдээллийн сан байгуулна.	2009-2012	Нийгмийн халамжийн арга хэмжээнд 203 өрх, жижиг зээлд 48 өрх, мэргэжил олгох сургалтанд 198 өрх, бусад хөнгөлөлт үйлчилгээнд 31 өрх, хамрагдсан бөгөөд Дэлхийн зөн, Адра, Ногоон алт зэрэг төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллаж, Адра олон улсын байгууллагын шугамаар Алдархаан сумын 4 өрх, Шилүүстэй сумын 1 өрхийг ногоо тарих сургалтанд хамруулж, төмс хүнсний ногооны үр олгосон нь амжилттай хэрэгжиж 2тн ургац хураан авсан. Мөн Тэс суманд 3 өрх, Идэр суманд 6 өрхөд үрийн төмс, ногооны талбай олгож, эдгээр өрхүүд орлогоо нэмэгдүүлэн ажиллах боломжтой болсон. Шилүүстэй сумын 1 өрх адра олон улсын байгууллагын сургалтанд хамрагдан эсгий үйлдвэрлэх тоног төхөөрөмж оруулж ирэн 2 хүнийг ажлын байраар хангалаа.	50
50	1.4.1 2.4		Нутгийн захиргааны байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн ядууралтай тэмцэх чадавхийг бэхжүүлэх арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлнэ.	2009-2012	Зам талбайн засвар, хотын гэрэлтүүлэг, хог цэвэрлэх, хадлангийн талбай хаших, малын тэжээл тариулах, хадлан тэжээл бэлтгэх, стадион засварлах, ойжуулалтын ажилд өрх бүрээс хүн хамруулж, нийт 203 хүнийг түр ажлын байраар хангасан.	30
51	1.4.1 5.1	Хүүхэд, залуучуудад эрүүл амьдралын дадал	"Хүн байхын учир" аяныг өргөжүүлж, хүүхэд, өсвөр үеийхний	2009-2012	“Гэр бүлдээ үүнийг хүснэ” гэр бүлийн зураг, зохион бичлэгийн уралдааныг Дэлхийн зөн ОУ-ын байгууллагатай	10

		олгох, аливаа хорт, муу зуршлаас ангид байх, тодорхой зорилго, тэмүүлэлтэй амьдрах хүмүүжил олгох чиглэлээр гэр бүл, аж ахуйн нэгж, байгууллагын санаачилгыг бүх талаар дэмжинэ.	"Гэр бүлдээ үүнийг хүснэ", "Миний паспорт", "Миний нэрийн хуудас" зэрэг хөдөлгөөн, үүсгэл санаачилгыг бүх талаар дэмжинэ.		хамтран зохион байгууллаа. Хүүхэд бидний хүслэн чуулганыг Даян-Очир зусланд 6 сарын 13,14-ны өдрүүдэд зохион явуулсан. Энэ чуулганд 4 салбар хуралдаанаар боловсрол, эрүүл мэнд, хүүхдийн оролцоо, хүүхдийн хамгаалал гэсэн сэдвүүдээр тулгамдаж байгаа асуудал, цаашид хийх зүйлүүдээр хүүхдүүд санал бодлоо солилцон "Томчуудад хүргэх бидний ил захидал"-ыг хүргүүллээ. Хүүхдийн оролцооны байгууллагыг хөгжүүлэхэд олон нийтийн үүргийг нэмэгдүүлэх нь сэдэвт Завхан Говь-Алтай аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөлийн хамтарсан зөвлөгөөний шийдвэр материалыг эмхэтгэн 65 ширхэг ном болгон гаргасан.	
52	1.4.1 5.2		Хүүхэд амралт, чөлөөт цагаа өнгөрөөж, мэдээлэл авч байгаа байдалд судалгаа хийж, хүүхэд, өсвөр үеийг хариуцлагатай, бүтээлч, тусч энэрэнгүй, нийгмийн идэвхитэй иргэн болгож төлөвшүүлэх талаар эцэг, эх, гэр бүлийн гишүүдийн мэдлэг хандлагыг өөрчлөх сургалт, сурталчилгааг өргөжүүлэх чиглэлээр ТББ-уудтай хамтран ажиллана.	2009-2012	Боловсролын хөгжил ба хүүхдийн эрх сэдэвт зохион бичлэг, TV –ийн хэлэлцүүлгийг нийгмийн ажилтан, багш нар, хүүхдүүд, эцэг эхчүүдийн дунд Дэлхийн зөн ОУ-ын байгууллагатай хамтран зохион байгуулж явуулсан. Мөн Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран ХТХ-ийн нэрэмжит сагсан бөмбөгийн тэмцээнийг ЕБС-дын 8-р ангийн хүүхдүүдийн дунд зохион байгууллаа. Хаврын баяр хүүхдийн ардын урлагийн наадмыг 10 төрлөөр зохион байгуулж явууллаа. Уралдаанд 280 гаруй хүүхэд оролцсон байна. "Хүүхдийн эрхийг хэн сайн мэдэх вэ?", "Боловсролын хөгжил ба хүүхдийн эрх" сэдэвт зохион бичлэг, телевизийн хэлэлцүүлгийг нийгмийн ажилтан, хүүхдүүд, багш эцэг эхчүүдийн дунд зохион байгуулсан.	50
53	1.4.1 5.3		Хүүхэд, өсвөр үеийнхний дунд эрүүл амьдралын дадал хэвшүүлэх, зохистой хооллолтыг эрхэмлэх, хорт зуршлаас татгалзах мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх талаар сургалт, сурталчилгааг өргөжүүлнэ.	2009-2012	Дэлхийн зөн ОУ-ийн байгууллагын "Завханхангай" ОНХХ, ЭМГ хамтран "Эх хүүхдийн хоол тэжээл" төслийг Канад улсын хөрөнгө оруулалттай 2 жил, "Эх хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулах нь" төслийг Австрали улсын хөрөнгө оруулалттай Дэлхийн зөн ОУ-ийн байгууллагын "Завхан" ОНХХ 3 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр болж" Аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан Сумын Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн дарга, эмч, Нийгмийн эрүүл мэндийн арга зүйч, эх баригч бага эмч нарыг оролцуулан 150 хүнд сургалт явуулж 2009 оны 3 дугаар сараас эхлэн амжилттай хэрэгжиж байна. Сум бүрээс 5 иргэдийн төлөөлөлтэй "Эх хүүхдийн хоол тэжээлийн байдал эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах" зөвлөгөөнийг 2 удаа, Сумдын их эмч, хүүхдийн хяналт, урьдчилан сэргийлэх тарилга хариуцсан бага эмч, хүүхэд ,эх барих эмэгтэйчүүдийн эмч, багийн эмч нарыг оролцуулан "Эх хүүхдийн хоол тэжээл,	30

					эрүүл мэндийн тусламжийг сайжруулахад бидний оролцоо” сэдвээр чуулга уулзалтыг ДЗОУБ-ын дэмжлэгээр зохион байгуулж, уриалга гарган ажиллаж байна.	
Нийгэм хамгааллын бодлогын хэрэгжилт						34
1.5 Хүн амын бодлого						
54	1.5.2.2	Эцэг, эх нь хүүхдээ эрүүл өсгөн бойжуулж, боловсрол, хүмүүжлийн зөв төлөвшилтэй болгон хөгжүүлэхэд чиглэсэн гэр бүлийн таатай орчин бүрдүүлэхийг дэмжинэ.	"Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил"-ийг зарлана.	2010	Аймгийн Засаг даргын захирамжаар Хүүхэд Залуучуудын ордны үйл ажиллагааг өргөтгөж, хүүхэд залуучууд, гэр бүлийн нийгэм, соёлын цогцолбор төв болгон 16 дугуйланг хичээллүүлж байна. Хөдөөгийн хүүхэд залуучуудын компьютерийн мэдлэгийг өргөжүүлэх, хүүхдийн хөгжил төлөвшилд үе тэнгийнхний оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Эрин зууны хөтөч” аяныг зарлан хөдөөгийн хүүхдүүдэд 149 компьютер олгож 1 суманд 5-10 компьютертэй 1 хүүхэд 5-10 хүүхдийн хөтөчөөр ажиллаж нийт 1300 хүүхэд хүрсэн үр дүнтэй ажил болсон. Аймгийн Засаг даргын 69-р захирамж гаргаж, ардын уламжлалт соёл урлагийг хөгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөг баталж 99 морин хуурч хүүхдүүд, 99 уртын дууч, 99 ардын бүжигчин хүүхдүүдийг бэлтгэсэн.	50
55	1.5.6.3	Ахмад настны эрүүл мэндийг сайжруулахад зориулан эмнэлэг, сувиллын газар, ахмадын ордон байгуулна.	Ахмадууд нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, тэдний чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх боломжийг бүрдүүлэх, чанартай насжилтыг дэмжих зорилгоор аймаг, дүүрэг бүрт орон нутгийн нөөц хөрөнгө, бололцоог ашиглан ахмадын ордон байгуулж ашиглалтад оруулна.	2010-2012	Аймгийн ахмадын амралт сувилал 2009 оны 2 сараас үйл ажиллагаа эхэлсэн бөгөөд энэ хугацаанд нийтдээ 9 сумын 83 ахмад настан болон ХБИ хамрагдсан байна. Аймгийн ахмадын хорооны байрыг ахмадууд чөлөөт цагаа өнгөрөөх төв болгон тохижуулахаар аймгийн Засаг даргын 2008-2012 хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрт тусган хэрэгжүүлж байна. Аймгийн ахмадын хорооны дэргэд ахмадын хөгжлийн танхим байгуулан 1,5 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд тус төвөөр 75 ахмад настан байнга үйлчлүүлж байна.	50
56	1.5.1.0.1	Хүүхдийн талаар бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад тэдний санаа бодол, хүүхдийн бодитой оролцоог дэмжинэ.	Хүүхэд, тэдний өөрийн удирдлагын байгууллага, хөдөлгөөн, хүүхдийн нэгдсэн зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ хүүхдийн хэрэгцээ шаардлагыг харгалзан тэдний санал хүсэлтийг шийдвэртээ тусгаж ажиллах талаар нутгийн захиргааны байгууллагыг зөвлөмжөөр хангаж ажиллана.	2009-2012	НҮБ-ын хүүхдийн сан, Хүүхдийн төлөө газрын төслөөр хүүхдийн оролцооны байгууллагыг чадавхижуулах сургалтыг аймагт хүүхдийн оролцооны байгууллагын төлөөлөгч хүүхдүүдийн дунд зохион байгуулав. Сургалтанд 17 хүүхэд хамрагдсан. Английн Хүүхдийг Ивээх сан, Хүүхдийн төлөө газартай хамтран “Хүүхдийн эрхэд суурилсан хандлага” сэдэвт сургалтыг насанд хүрэгчдийн дунд явуулж, 20 хүн хамрагдлаа. Завхан Говь-Алтай аймгийн хүүхдийн нэгдсэн зөвлөлийн гишүүдийн зөвлөгөөний материалаар “Хүүхдийн оролцооны байгууллагыг хөгжүүлэхэд, олон нийтийн үүргийг нэмэгдүүлэх нь” номыг гаргасан."Завхан нутгийн хүүхдүүд" сониныг улирал бүр тогтмол гаргаж байна.	50

					Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн дэргэд “Хүүхдийн төлөө санг” нээж сандаа 3,5 сая төгрөг, сумдад нийт 2,8 сая төгрөгийг тус тус төвлөрүүлээд байна. Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн зорилтыг тодорхойлж, “Хүүхдийн хөгжил хамгааллын төлөө” уриайн дор аяныг аймгийн хэмжээнд өрнүүлж аймгийн Засаг даргын 04 тоот албан даалгаврыг гарган хэрэгжүүлж ажилласан. Хүүхдийг тэвчишгүй хүнд хөдөлмөр эрхлэхээс сэргийлэх чиглэлээр аймгийн хэмжээнд хүүхдийн хөдөлмөрийн байдалд хяналт үнэлгээ тогтоож, аймгийн хэмжээнд хүүхдийн хөгжил хамгааллын асуудал 73 хувьтай гарсан.	
Хүн амын бодлогын хэрэгжилт						50
2.1 Макро эдийн засгийн бодлого						
57	2.1.1.1	ДНБ-ий жилийн дундаж өсөлтийг жилд 12 хувиас доошгүй түвшинд хүргэн, эдийн засгийн хурдацтай хөгжлийн нөхцөлийг бүрдүүлнэ.	Эдийн засгийн салбаруудын үйл ажиллагааг өргөжүүлэх замаар өсөлтийг нэмэгдүүлнэ.	2009-2012	Экспортын баримжаатай үйлдвэрлэлийн үндэс суурийг тавих зорилгоор “Завхан үйлдвэр технологийн парк”-ийн зураг төсөв, техник-эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ зэргийг хийлгэн, 16,3 га газрыг эзэмшилд олгосон боловч хөрөнгө оруулалт, эрх зүйн орчин бүрдээгүйн улмаас хэрэгжилт удааширч байна. Эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлж, ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засгийн өсөлтөд мэдэгдэхүйц нөлөө бүхий салбар болгоход анхаарч ажиллаж байна.	30
58	2.1.2.1	Эдийн засгийн өсөлтийг хангах, макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг бататгах, хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг хөгжлийн тэргүүлэх чиглэлд оновчтой хуваарилах замаар хүн амын бодит орлого, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, бодит салбарын хөгжлийг тэтгэхэд чиглэсэн төсөв, мөнгөний бодлогыг хэрэгжүүлнэ.	Үндэсний хөгжлийн цогц бодлоготой уялдуулан Төсвийн хүрээний дунд хугацааны мэдэгдэл, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлийн шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгож, дунд болон урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэх санхүүгийн төлөвлөлт, зохицуулалтыг сайжруулна.	2009-2010	Завхан аймгийн хөгжлийн цогц бодлогыг аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, жил жилийн төсөв, Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрүүд болон энэ баримт бичгийн хүрээнд боловсруулан хэрэгжүүлэх дунд хугацаа (2-5 жилийн)-ны хөгжлийн баримт бичиг, дэд хөтөлбөр, мастер төлөвлөгөө, төслүүдэд тусган хэрэгжүүлж байна. Төсвийн хүрээний дунд хугацааны мэдэгдэл болон эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулахад анхан шатны нэгжийн саналын үндэслэлийг сайжруулахад анхаарч ажиллаж байна.	30
59	2.1.2.2		Ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх үндэсний тооцооны шалгуур үзүүлэлт, тэдгээрийн хүрэх	2009-2010	Ажлын байр шинээр бий болгосон аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, ажилгүй, ядуу, нэн ядуу иргэдэд мэргэжил, ажлын дадлага туршлага эзэмшүүлэх, бага орлоготой малчин залуусыг уламжлалт мал	30

			түвшин, хөрөнгө оруулалтын хэрэгцээг оновчтой тодорхойлж, эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжлийн тэнцвэрийг бататгах макро эдийн засгийн зохицуулалтын орчныг сайжруулна.		маллагааны арга барилд сургах сургалтуудыг олон улсын хүмүүнлэгийн байгууллагууд, МСҮТ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтран зохион байгуулж байна. 2009 онд ЖДҮ-ийг дэмжих сангийн хөрөнгөөр 22 сумын 81 төсөл хэрэгжүүлэгч үйлдвэр, аж ахуйн нэгж иргэдэд нийт 780.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосноор нийт 25 үйлдвэрлэл шинээр бий болж, 334 ажлын байр шинээр нэмэгдлээ.	
60	2.1.2.6		Улсын төсвийн болон Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэгийг бүсийн тулгуур төв, орон нутгийн хөгжлийн төв хотуудын зорилтот хөтөлбөр, төсөл, арга хэмжээтэй уялдуулан хуваарилж хэрэгжүүлнэ.	2009-2012		
62	2.1.2.7.3	Шударга өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, өрсөлдөөний тухай ойлголт, соёлыг нийгмийн сэтгэл зүйд төлөвшүүлж, зах зээлийн өрсөлдөөний орчныг бүрдүүлнэ.	Шударга өрсөлдөөнийг дэмжих, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.	2009-2010	Аймгийн Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгтэй хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр гэрээ байгуулан ажиллах, хэрэглэгчдийг хэрэглээний соёл эзэмшүүлэх сургалт зохион байгуулах, хэрэглэгчдэд мэдээлэл зөвлөгөө өгөх, хэрэглэгчдийн эрх ашиг түгээмэл хөндөгддөг захуудад хяналт тавих зэрэг арга хэмжээг авч ажиллаж байна. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах дэд хөтөлбөрийг боловсруулж байна. Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авахад шударга өрсөлдөж байгаа эсэх, монополь байдалтай аж ахуйн нэгжүүдийн үйлчилгээний үнийг өөрчлөх тухай бүр өөрчлөх шалтгаан нь үндэслэлтэй эсэхэд хяналт тавин ажиллаж байна.	30
63	2.1.2.7.4		Зах зээлийн өрсөлдөөний тухай ойлголт, соёлыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, үндэсний болон олон улсын хэмжээний хурал, семинар зохион байгуулна.	2009-2012	Зах зээлийн өрсөлдөөн, түүний эрх зүйн зохицуулалт, Үйлчилгээний соёлыг сайжруулах, Хүнсний аюулгүй байдлын хяналтын тогтолцоо зэрэг сэдэвт сургалтуудыг 3 удаа, Эрүүл орчин-Аюулгүй хүнс уулзалт зөвлөгөөнийг сумдын ЗДТГ, ЭМГ, МХГ-тай хамтран зохион байгуулж сургалт зөвлөгөөнд 700 орчим хүнийг хамрууллаа.	50
64	2.1.2.8.4	Үндэсний бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанар, өрсөлдөх чадвар, хэрэглээний аюулгүй байдлыг дээшлүүлэх, экологийн аюулгүй орчныг бүрдүүлэх, хэрэглэгчийг чанартай, аюулгүй бүтээгдэхүүнээр хангахад стандартчилал, хэмжил	Бүсийн болон аймгийн төвд сорилт, хэмжил зүйн үйлчилгээг нэг цэгийн зарчимд шилжүүлнэ. Хэрэглээний зүйлс, барилга, хүрээлэн буй орчны чанар, аюулгүй байдлын сорилт, шинжилгээг орчин үеийн шаардлагын хэмжээнд хийдэг сорилтын лабораторийн үндэсний тогтолцоог бий болгоно.	2009-2010	Хими, бактериологийн шинжилгээ буюу сорилын шинжилгээг аймгийн МХГ дээр Хэмжил зүйн лаборатори нь аймгийн СХЗТ дээр үйл ажиллагаа явуулж байна. Хэмжил зүйн лаборатори нь цул, цахилгаан, хий, шингэн, эзлэхүүн зарцуулалтын хэмжлийн баталгаажуулалт хийж байна. Цаашид дээрхи 2 лабораторийг нэгдсэн нэг цэгийн үйлчилгээний зарчимд шилжүүлэх зорилгоор тус лабораториудыг нэг байгууллагад нь шилжүүлэх буюу хөндлөнгийн лаборатори байгуулах талаар холбогдох газруудад санал тавьсан.	30

		зүй, тохирлын үнэлгээгээр дэмжлэг үзүүлэх ажлыг эрс сайжруулна.				
Макро эдийн засгийн бодлогын хэрэгжилт						28,5
2.2 Үйлдвэржүүлэх бодлого						
65	2.2.5.1	Боловсруулах үйлдвэрийн монгол брэндийг бий болгож, ноолуур, хонь, тэмээний ноос, арьс, ширэн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүн болгох үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	Боловсруулах үйлдвэрийн үндсэн салбаруудыг харилцан уялдаа бүхий хоршилт, төрөлжсөн хэлбэрээр хөгжүүлж, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлтийг хангах цогцолборууд байгуулна.	2009-2012	Аймгийн эдийн засаг, нийгмийг 2008, 2009 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд бодит салбарын хөгжлийг эрчимжүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор 8-12 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна. 2009 онд ЖДҮ-ийг дэмжих сангийн хөрөнгөөр 22 сумын 81 төсөл хэрэгжүүлэгч үйлдвэр, аж ахуйн нэгж иргэдэд нийт 780.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон ажилгүйдэл, ядуурлын түвшинг бууруулах, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэхэд чухал алхам болж байна. Одоогийн байдлаар тус зээлийн хүрээнд 25 үйлдвэрлэл шинээр бий болж, 334 ажлын байр бий боллоо.	30
66	2.2.5.2		Газар зүйн заалттай бүтээгдэхүүн бий болгох ажлыг эрчимжүүлж, нэр төрлийг олшруулна.	2009-2011	Завхан аймагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг газар зүйн заалттай болгох ажлыг эрчимжүүлэх зорилгоор ХАҮТ бүтээгдэхүүний судалгаа гаргаж холбогдох газруудад санал тавьснаар манай аймгийн улаан хальст сармис, нэрсний варень газар зүйн заалттай бүтээгдэхүүн боллоо.	30
67	2.2.5.3		Салбарын эрдэм шинжилгээний байгууллагын чадавхийг дээшлүүлэн, шинжлэх ухаан үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг идэвхжүүлнэ.	2009-2011	МУИС-ийн харъяа аймгийн Эдийн засгийн салбар сургуулийн дэргэд 2006 оноос “Баруун бүсийн нийгэм, эдийн засгийн судалгааны төв” байгуулагдан ажиллаж байна. Тус төв нь бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн байдалд судалгаа явуулж, бодит байдалд дүн шинжилгээ хийж, зөвлөмж гарган ажиллаж байна. Өнгөрсөн хугацаанд “Улиастай сумын бизнесийн орчны судалгаа”, “Завхан аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн байдал, төлөвийн судалгаа”, “Завхан аймгийн хөдөлмөрийн зах зээл, хүний нөөцийн байдлын судалгаа”, “Баруун бүсийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн байдал, хандлага” зэрэг судалгааны ажлуудыг хийж холбогдох газруудад хүргүүлэн ажиллалаа.	30
68	2.2.5.4		Боловсруулах үйлдвэрүүдийн мэргэжилтэй ажилчин, инженер техникийн ажилтан бэлтгэх тусгай хөтөлбөр баталж хэрэгжүүлнэ.	2009-2012	Аймгийн МСҮТ-ийн сургалтийн хөтөлбөрт орон нутагт хэрэгцээ шаардлагатай үйлдвэрүүдэд ажиллах техник, технологийн мэргэжил эзэмшүүлэх сургалтыг явуулах, боловсруулах үйлдвэрүүдийн мэргэжилтэй ажилчин, инженер техникийн ажилтан бэлтгэх аймгийн хөтөлбөр боловсруулж байна. МУИС-ийн ЭЗсС бүс нутгийн онцлог, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн Аялал жуулчлалын менежмент, Татварын нябо хяналтын анги, МСҮТ Компьютер электроникийн засварчны ангийг шинээр нээн	30

					хичээллүүлж байна. Тосонцэнгэлд ойн нөхөн сэргээлт, жимс жимсгэнэ, ХАА-н машин механизмын засварын ангийг шинээр нээхээр төлөвлөн холбогдох газарт саналаа хүргүүлээд байна.	
69	2.2.6.1	Дотоодын түүхий эдэд түшиглэн цемент, арматур төмөр хийц, шил зэрэг барилгын материалын хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжийг бүрдүүлнэ.	Уул уурхайн үйлдвэрийг түшиглэн барилгын материалын үйлдвэр орон нутагт байгуулахыг дэмжинэ.	2010-2011	Аймгийн тэргүүлэх чиглэлийн салбарт барилгын материалын үйлдвэрийг байгуулах ялангуяа барилгын ханын материалын үйлдвэрийг түлхүү дэмжин хөгжүүлэх зорилгоор блок, тоосгоны 7 үйлдвэрийг 114.6 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрууллаа.	30
70	2.2.7.2	Аймгуудын онцлог, эрэлт хэрэгцээнд нийцсэн жижиг үйлдвэр, үйлдвэрлэл технологийн паркийг байгуулж, орон нутгийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул, Завхан аймгуудад үйлдвэрлэл, технологийн парк байгуулахад шаардлагатай дэд бүтцийг байгуулна.	2009-2012	Улиастай-үйлдвэрлэл, технологийн паркийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, Мастер төлөвлөгөө боловсрогдон, байгаль орчны үнэлгээ хийгдэж, аймгийн төвийн Өлзийт багийн 16.2 га газарт ҮТП байгуулахаар төлөвлөгдсөн байна. 2010 онд Дэнжийн районы 4 км хатуу хучилттай зам барих, дээрхи чиглэлд гэрэлтүүлэг тавих зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөөд байна.	30
71	2.2.7.4		Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх үндсэн чиглэлийг нарийвчлан тогтоож, бүс нутгаар үйлдвэр, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлнэ.	2009-2012	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх бодлого”-ын баримт бичгийн төсөл боловсруулах ажлын хэсэгтэй ярилцаж, Аймгийн тэргүүлэх ач холбогдол бүхий жижиг, дунд үйлдвэрүүдийн жагсаалтыг гаргасан болно. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Мах боловсруулах үйлдвэрийг сэргээн засварлаж өргөтгөх • Жимс, жимсгэнэ боловсруулах үйлдвэр хөгжүүлэх /Чацаргана, нэрс, аньс/ • Эмийн ургамал боловсруулах болон рашаан савлах үйлдвэр байгуулах • Завханы улаан хальст сармисны тариалалтыг нэмэгдүүлж, сармисны ханд бэлтгэх үйлдвэр байгуулах • Сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэр • Ноос, ноолуур гүн боловсруулах үйлдвэр байгуулах • Мод модон эдлэлийн үйлдвэрийг өргөжүүлэх Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх /Тоосгоны үйлдвэр болон барилгын ханын материалын үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх	30
72	2.2.7.5		Аймаг, сумдын 10. 15. 35 кв-ын шугамын трассын дагуу дундын хэрэглэгчдийг хамруулж, жижиг трансформаторын дэд станц барих бодлого баримталж ажиллан, орон	2009-2012		

			нутагт инженерийн хийцтэй худаг гаргах усны хайгуулын зарим ажлыг сумдын цахилгаан дамжуулах агаарын шугамын дагуу хийнэ.			
73	2.2.2 8.1	Экологийн цэвэр сүү, цагаан идээ, мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.	"Сүү" хөтөлбөрийг хэрэгжүүлж, махны нөөцийн сан байгуулна.	2009-2012	Сүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр батлан хэрэгжүүлж байна. Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойшхи хөтөлбөрийн хэрэгжилт 50 хувь байна. Дээрх хөтөлбөрийн хүрээнд Тосонцэнгэл, Идэр сумдад сүү боловсруулах тоног төхөөрөмж нийлүүлж үйл ажиллагаа явуулж байна. ЖДҮ-ийг хөгжүүлэх зээлээс сүүний чиглэлээр 4 иргэн аж ахуйн нэгжид 56,9 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олголоо.	30
74	2.2.3 0.1	Ашигт малтмалыг түүхий эд хэлбэрээр гаргахыг үе шаттайгаар багасгах, түүнчлэн экспортлож байгаа бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг шат дараалалтай ахиулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.	"Чацаргана" хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	2009-2012	Аймгийн ИТХ-аар "Чацаргана" хөтөлбөрийг боловсруулан батлуулж, чацаргана тариалах болон жимс, жимсгэнээр эцсийн бүтээгдэхүүн үйлвэрлэх иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин ЖДҮ-ийг дэмжих сангийн хөнгөлөлттэй зээлд хамруулан үйл ажиллагааг нь дэмжиж нийт 35.6 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олголоо.	50
Үйлдвэржүүлэх бодлогын хэрэгжилт						29
2.3 Хөдөө аж ахуй, Хүнсний аюулгүй байдлын бодлого						
75	2.3.1. 2	Хүн амын хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн мах, сүү, гурил, төмс, гол нэрийн хүнсний ногоогоор бүрэн хангах зохион байгуулалтын арга хэмжээ авна.	Сүүний хангамжийг нэмэгдүүлэн, сүү, сүүн бүтээгдэхүүний чанар, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг сайжруулан, удаан хугацаагаар хадгалагдах сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ.	2009-2012	Аймгийн ХХААЖДҮГ-ын мал эмнэлэг, ариун цэврийн лабораторит мах, сүүний төрөлжсөн захаар худалдаалагдаж буй малын гаралтай түүхий эдийг / 2 удаа/ 31 дээжийг хамруулан шинжилж, хүнсний аюулгүй байдал зөрчигдөөгүй байгаа гэсэн дүгнэлт гарсан. Сүү, сүүн бүтээгдэхүүний 5 үйлдвэрийг дэмжин 57.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамруулсан болно.	50
76	2.3.1. 3		Малчид, фермерүүдийн сүүг сүү үйлдвэрлэгчид нэгдсэн байдлаар цуглуулах, хөргөх, боловсруулах сүү бэлтгэлийн тогтолцоог бүрдүүлэн ажлын байр нэмэгдүүлж, хүн амын амьжиргаа, хүнсний аюулгүй байдлыг хангана.	2009-2012	Аймагт фермерийн аж ахуй байгуулж хөгжүүлэх чиглэлээр 14 төсөл ирүүлснийг бодлогын түвшинд дэмжин сүүний чиглэлийн 10 жижиг үйлдвэрлэлийн төслийг 112.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрууллаа. Аймаг суманд сүүний үйлдвэр байхгүйн улмаас сүү цагаан идээг захаар худалдаалж байна. 2009 онд 33120.6 мянган литр сүү үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 11 хувиар илүү байна.	30
77	2.3.1. 4		Буудайн гурилыг амин дэм, эрдэс бодисоор баяжуулахад шаардагдах холигч төхөөрөмж, премиксийг хөнгөлөлттэй нөхцөлөөр нийлүүлнэ.	2009-2012	Алдархаан сумын Өгөөмөр багийн Шар талд 200.0 га талбайд улаанбуудай тариалж, Улиастай суманд хоногт 25.0 тн-ын хүчин чадалтай гурилын үйлдвэр шинээр байгуулахаар тоног төхөөрөмжийг суурилуулж байна.	30
78	2.3.1.		"Ногоон хувьсгал" хөтөлбөрийг	2009-2012	Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээнд 35 аж ахуйн нэгж,	30

	5		хэрэгжүүлнэ.		3390 өрх хамрагдаж төмс 1673.7 тн, хүнсний ногоо 878.5 тн-ыг хураан авлаа.	
79	2.3.1.6		Дотоодын хүнсний түүхий эдэд тулгуурласан нярай хүүхдийн хоол тэжээлийн болон түүнд чиглэсэн үйлчилгээтэй хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.	2009-2012	Иод дутлын эмгэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн иоджуулсан давсны үйлдвэрүүдтэй гэрээ байгуулан эмзэг бүлгийн хүмүүс, жирэмсэн эхчүүдийг оролцуулсан өдөрлөг зохион байгуулж, оролцогчдод 5,5 кг давс үнэгүй олголоо. "Монгол хан" хоршооны төслийг дэмжин ХХААХҮЯ-д хүргүүлэх арга хэмжээ авсан.	30
80	2.3.5.1	Газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх "Атрын 3 дахь аян"-ыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, усалгаатай тариалан эрхлэх, техникийн парк шинэчлэлтийн бодлогыг	Тариалангийн талбайн бүртгэл, тооллого явуулж, эзэмшилт, ашиглалтыг сайжруулна.	2009-2012	Аймгийн хэмжээнд тариалангийн 63517.3 га талбай байгаагаас 11532 иргэнд 2016.6 га талбайг, 28 төрийн байгууллагад 135.4 га талбайг, 34 аж ахуйн нэгжид 357.1 га талбайг тус тус эзэмшүүлж байна. Энэхүү эзэмшүүлсэн 2509.1 га талбайгаас 1061.8 га-д тариалалт хийж төмс, хүнсний ногоо 2552.2 тн, малын тэжээл 549.1 тн, үр тариа 118.1 тн-ыг хураан авлаа.	50
81	2.3.5.2	боловсруулж, техник, технологийн шинэчлэл хийх ажлыг эрчимжүүлж, хамгаалагдсан хөрсний тариаланг нэмэгдүүлнэ. Шинэ төрлийн таримал тариалах, үр сортын шинэчлэл хийх, таримал ургамлыг хамгаалах тогтолцоо бүрдүүлнэ.	Таримал ургамал, үр үржүүлгийн аж ахуй байгуулах, үрийн сорт, нэр төрлийг олшруулах, ганд тэсвэртэй болон усалгаатай нөхцөлд тариалах сортын үрийн хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2009-2012	Солонгос улсын FnP компанитай хамтран цөлийн бүс нутагт "Ганд тэсвэртэй ургамал тариалах" 10 сая долларын өртөг бүхий төслийг хэрэгжүүлж эхлээд байна. Дөрвөлжин, Эрдэнэхайрхан, Улиастай сумдад туршилтын талбай байгуулан судалгааны ажил хийгдэж байна.	50
82	2.3.5.3		Улаан буудайн нөөц бүрдүүлэх, хүрэлцээ, хангамжийг сайжруулах зорилгоор борлуулалтын сүлжээ бий болгоно.	2009-2012	Аймгийн хэмжээгээр 256.5 га-д үр тариа тарьж 118.1 тн ургац хураан авлаа.	10
83	2.3.5.4		"Атрын 3 дахь аян" тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	2009-2012	Энэ онд шинээр аж ахуйн нэгж, иргэдэд трактор, комбайн 9-ийг олгож, төмс хүнсний ногооны үр 110 тн-ыг нийлүүллээ. Тариаланчдын сургалтыг 3 удаа зохион байгуулж 160 хүнийг хамруулав. Хөтөлбөр хэрэгжүүлснээр төмс 1673.7 тн, хүнсний ногоо 878.5тн, үр тариа 168.1 тн, малын тэжээл 549.1 тн-ыг хураан авлаа.	30
84	2.3.5.5.		Улаан буудайн үйлдвэрлэлд төрөөс дэмжлэг хэлбэрээр үзүүлэх урамшууллын системийг боловсронгуй болгоно.	2009-2012	2009 онд улаан буудайн үйлдвэрлэлийн урамшуулал авах болзлыг биелүүлсэн аж ахуйн нэгж, иргэн байхгүй байна.	10
85	2.3.6.1	Малын чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх, үржлийн ажил, үйлчилгээний хүртээмж, үр дүнг сайжруулан, сүргийн бүтцийг оновчтой байлгах бодлого	Нутгийн болон сайжирсан, цэвэр үүлдрийн малын удмын санг хамгаалах, өсгөх, мал үржүүлгийн болон биотехнологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэх замаар мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлнэ.	2009-2012	Алдархаан, Дөрвөлжин, Ургамал, Эрдэнэхайрхан, Яруу, Улиастай, Цагаанхайрхан сум, цөм сүргийн аж ахуйн 490,3 мянган мал, үүний дотор 6,6 мянган хээлтүүлэгч малд үзлэг ангилалт хийж, 177,1 мянган малыг үржилд тэнцүүлж 133 гойд ашиг шимтэй мал шалгаруулж, Завхан Буурал омгийн цөм сүргээс ишгэн ухна 370, сартуул үүлдрийн цөм сүргээс хурган хуц 663 нийтдээ 1033	50

		хэрэгжүүлнэ.			хээлтүүлэгч шинээр тавилаа. Малын удмын сангийн үндэсний төвөөс мэргэжилтэн ирж „Дөрвөлжин суманд Завхан буурал омгийн шилмэл ухны үрээр 150 эм ямаа, нутгийн тулман хөхтэй ямааны чанар, сүүний гарцыг нэмэгдүүлэхээр 15 эм ямааг сүүний өндөр ашиг шимт Занен үүлдрийн ухны гүн хөлдөөсөн үрээр, Эрдэнэхайрхан суманд мах ноосны Сартуул үүлдрийн шилмэл хуцны үрээр 144 эм хонь, хонины амьдын жин нэмэгдүүлэх, цус сэлбэх зорилгоор мах нарийвтар ноосны өндөр ашиг шимтэй Суффолик үүлдрийн хуцны гүн хөлдөөсөн үрээр 50 эм хонь, сүүний Альпийнский үүлдрийн ухны гүн хөлдөөсөн үрээр 20 эм ямаанд тус тус зохиомол хээлтүүлэг хийлээ.	
86	2.3.6.2		Цаа буга, тэмээний удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, өсгөх, ашиг шимийг зохистой ашиглах замаар цаачид, тэмээчдэд дэмжлэг үзүүлнэ.	2009-2012	Тэмээн сүргийг өсгөх, ашиг шимийг бүрэн ашиглахад чиглэгдсэн “Мөнгөн буур”-ын болзлыг ИТХ-ийн тэргүүлэгчдийн 2009 оны 54-р тогтоолоор батлан гаргалаа. Болзлыг 2010 оноос дүгнэж эхлэнэ.	10
87	2.3.6.3		Цөм сүргийн малыг үржлийн бүртгэлд бүрэн хамруулж, улсын хэмжээнд үржүүлж байгаа арвин ашиг шимт цөм сүргийн малын удам гарваль, ашиг шимийн мэдээллийн сан бий болгоно.	2009-2012	Цөм сүрэгт 231.7 мянган мал бүртгэгдсэн нь нийт сүрэгт 8.2 хувийг эзэлж өмнөх оноос 0.6 хувиар өссөн байна. 2010 онд аймгийн цөм сүргийн малыг бүртгэлжүүлэх, индексжүүлэх, хээлтүүлэгч малыг үржлийн нэгжийн мэдэлд авах ажлыг зохион байгуулахаар үндсэн чиглэлд асуудал тусгах санал оруулаад байна.	30
88	2.3.6.4		Малын үржлийн ажил үйлчилгээний хүртээмж, үр дүнг сайжруулах зорилгоор цөм сүргийн үржлийн нэгжийн чадавхийг сайжруулах асуудлыг судалж холбогдох арга хэмжээг авна.	2009-2012	Монгол улсын төрийн өмчийн хороо, хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас манай аймгийн цөм сүргийн төвийн үйл ажиллагаанд 2009 оны 6-р сард шалгалт хийж, аймгийн малын чанарыг сайжруулах түшиц газар байлгахгаар шийдвэрлэж, цөм сүргийн үржлийн аж ахуй болгон бүтэц зохион байгуулалтын хувьд шинэчилсэн. Цөм сүргийн үржлийн аж ахуй нь жил бүр Сартуул үүлдрийн хуц 300, Завхан Буурал омгийн ухна 50 толгойг бойжуулж, аймаг сумын хэрэгцээнд гэрээгээр нийлүүлж малын чанарыг сайжруулах үүрэгтэй ажиллаж байна.	30
89	2.3.7.1	Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийг зааглан тогтоож, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх бүсийн хэмжээнд загвар	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгуудыг аймаг, сум бүрээр тусгайлан тогтоож, тухайн бүс нутагт буй бэлчээрийн малыг өндөр ашиг шимт малаар сольж, өөрчлөх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.	2009-2012	Улиастай, Тосонцэнгэл, Тэлмэн зэрэг төв суурин газар, услалтын систем бүхий 6 суманд эрчимжсэн аж ахуй эрхлэх зорилгоор бэлчээр, тариалангийн нутаг олгож, худаг уст цэг гарган өгч усалгаатай газар тариаланг эрчимжсэн мал аж ахуйтай хослон эрхлэх бодлогыг баримтлан ажиллаж байна.	10
90	2.3.7.2	фермерийн аж ахуй байгуулах бодлого барьж,	Сүү, махны арвин ашиг шимт мал, амьтны тоог нэмэгдүүлэх, үржлийн	2009-2012	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 54 дүгээр тогтоолоор нутгийн	30

		энэ чиглэлээр нутгийн өөрөө удирдах байгууллагуудтай хамтран ажиллана.	сүрэг бий болгох үйл ажиллагааг урамшуулна.		арвин ашиг шимтэй тэмээ, адуу, үхэр сүргийн тогтвортой өсөлтийг хангах, үржлийн цөм сүрэг бий болгох үйл ажиллагааг дэмжиж урамшуулах зорилгоор мал бүхий иргэд, малчдын бүлэг, аж ахуйн нэгжүүдийн дунд болзол гаргалаа. Болзлыг 2010 оноос эхлэн жил бүр дүгнэх юм.	
91	2.3.7.3		Бүсийн тулгуур төв болон орон нутгийн хөгжлийн төвүүдийн ойролцоо фермерийн аж ахуйг цогцолбор байдлаар хөгжүүлэх загвар бий болгоход дэмжлэг үзүүлнэ.	2009-2012	Улиастай, Тосонцэнгэл, Алдархаан сумдад "Миний тулга" ХХК, "Буурлын рашаан" ХХК, "Дэлгэрэх Алдар" ХХК-нууд нь 10-30 үнээ бүхий сүүний үхрийн эрчимжсэн аж ахуй эрхлэж хүн амын хүнсний хэрэгцээнд сүү сүүн бүтээгдэхүүн гэрээгээр нийлүүлж байна.	50
92	2.3.8.1	Хөдөөгийн иргэд бэлтгэсэн түүхий эд, бүтээгдэхүүнээ хэрэглэгчид шууд худалдаалах боломж бүрдүүлсэн мэдээллийн технологид суурилсан биржийн сүлжээ байгуулна.	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бирж байгуулан ажиллуулна.	2009-2012	Биржийн тухай хуульд оруулах саналыг ХХААХҮЯ-нд хүргүүлэв.	10
93	2.3.8.2		Сум бүрт түүхий эд бэлтгэлийн анхан шатны хоршоо, нөхөрлөл байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	2009-2012	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, түүхий эд бэлтгэлийн ажлыг шат дамжлага багатай зохион байгуулах талаар сумдаас санал авч байна.	10
94	2.3.1 0.1	Малын тэжээлийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлж, тэжээлийн шимт чанар, тэжээллэг байдлыг сайжруулан, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	"Малын тэжээл хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэн, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	2009-2012	Аймгийн хэмжээнд байгалийн хадлан 40,0 мянган тонн, ногоон тэжээл 0,5 мянган тонн, гар тэжээл 2,0 тонн бэлтгэх даалгавар өгөгдсөнөөс хадлан 10,4 мянган тонн, ногоон тэжээл 549,0 тонн, гар тэжээл 996,3 тонн бэлтгэж, хадлан 26,0 хувь, ногоон тэжээл 109,8 хувь, гар тэжээл 49,8 хувийг тус тус бэлтгэсэн. ХХААХҮЯ-наас таримал, малын тэжээлийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор улаан буудайн үр 27,0 тонн, овъёосны үр 8,0 тонн, хөх тарианы үр 6,0 тонн, царгасны үр 60,0 кг олгосныг тариалан эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжүүдэд хуваарилан тарааснаар улаан буудай 65,5 тонн, малын тэжээл 524,5 тн бэлтгэсэн байна. Аймгийн Засаг даргын аюулгүйн нөөцөд өвс 100 тонн, тэжээл 125 тонн, сумдын мэдээллээр сумдын аюулгүйн нөөцөд 1,9 мянган тонн өвс бэлтгэсэн.	50
95	2.3.1 0.2		Хадлан болон тэжээл үйлдвэрлэлд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, тэжээлийн хангамж, чанарыг сайжруулах, хадгалалт, тээвэрлэлтийн зардлыг бууруулах арга хэмжээ авна.	2009-2012	Баянтэс, Тэс сумын хилийн зурвас, Тэлмэн сумын хүрэн тал, Алдархааны борхын булан, Идэр сум, Бага хайрханы отрын бүс нутаг зэрэг байгалийн хадлан түлхүү бэлтгэх, ногоон тэжээл, тэжээлийн олон наст тариалах боломж сайтай газруудад хүчин чадал сайтай дунд оврын трактор, бүрэн агрегатын хамт олгох, иргэд аж ахуйн нэгжид хадлангийн техник хэрэгслийг эзэмшүүлэн өөрсдийн хүчээр өвс, тэжээл бэлтгэн улсын нөөцийн	50

					цэгүүдэд бэлтгүүлэх арга хэмжээ авч ажиллалаа. Тэлмэн суманд Тэлмэн дэлгэрэх ХХК ногоон тэжээл 105 тонн, Ногоон алт төслийн тракторын салаа 70,0 тонн ногоон тэжээл ,мөн энэ салаа хойд хилийн зурвасаас 40 тонн хадлан, Тэс сумын хадлангийн 2 трактор бүхий салаа Увсын Баруун туруунаас улсын нөөцөд 2000 мянган боодол буюу 50 тонн өвс тус тус бэлтгэн нийлүүлэв.	
96	2.3.1 1.3	Бэлчээрийн газрыг эзэмших, ашиглахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.	Аймаг болон сум дундын отрын бүс нутгийг өргөжүүлж, материаллаг баазыг бэхжүүлнэ. Отрын бүс нутгийн бэлчээрийн нөхөн сэргээлт, хамгаалалтыг сайжруулан зохистой ашиглах арга хэмжээ авна.	2009-2012	Энэ оны 10-р сарын 08-ны өдөр ХХААХҮЯ-ны аймаг дундын отрын бүсийн захиргаа, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Аймгийн Засаг даргын Тамгын газар, харъяа хэлтэс агентлагуудын удирдлага, 24 сумын Засаг дарга, багийн Засаг дарга нар малчны төлөөлөл 120 гаруй хүн оролцсон Өвлийн отор-2009 зөвлөгөөн зохион байгуулав. Зөвлөгөөнөөр Бага хайрханы аймаг дундын отрын бүсэд 8 сумаас 96 өрхийн 74,0 мянган мал, отроор өвөлжүүлж, хаваржуулах зохион байгуулав. Отрын бүс нутгийн хэмжээнд хашаа, хороо барих, бэлчээр хаших, усжуулах талаар ХХААХҮЯ тай хамтран ажиллаж байна.	30
97	2.3.1 2.2	Мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах ажлыг олон улсын жишгийн дагуу хийж, мал эмнэлгийн оношлогоо, шинжилгээний лабораторийн чадавхийг дээшлүүлэх, сумдын мал эмнэлэг, үржлийн нэгж болон Биокмбинатыг хөрөнгө оруулалтаар дэмжиж, дотоодын үйлдвэрийн малын эм, вакцины чанарыг сайжруулж хангамжийг нэмэгдүүлнэ.	Хил дамжин халдварладаг малын гоц халдварт шүлхий, хонь, ямааны цэцэг, гахайн мялзан, шувууны томуу өвчний дэгдэлтээс эрт сэрэмжлүүлэн, хариу арга хэмжээг хэрэгжүүлэн, уг өвчнөөр тайван нөхцлийг хангаж ажиллана.	2009-2012	Энэ онд халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд зориулж 20 нэр төрлийн 344.4 сая төгрөгийн эм био бэлдмэлийг татан авч 48 мал эмнэлэг үржлийн нэгжүүдэд хуваарийн дагуу олгон 3138,4 мянган малыг халдварт өвчнөөс сэргийлэх вакцинд хамруулсан байна. Паразиттах өвчнөөс сэргийлэхэд 3 нэр төрлийн 5970,0 мянган төгрөгний эм бэлдмэлийг улсын төвлөрсөн төсвөөс мөн мал эмнэлэг үржлийн нэгжүүд өөрийн хөрөнгөөр 20,0 сая төгрөгийн эм бэлдмэлээр 569,0 мянган малыг эмчлэн сэргийлэх арга хэмжээнд хамруулаад байна. Лабораторийн оношийн бэлдмэл 18 нэр төрлийн 457,8 мянган төгрөгний оношлуур авч 24,7 мянган дээжид шинжилгээ хийсэн байна. Ариутгал халдваргүйжүүлэх арга хэмжээнд 2 нэр төрлийн 7263,2 мянган төгрөгийн бодис авч 49 аж ахуйн нэгжүүдэд хуваарилан олгож, 772,0 мянган метр квадрат талбай , 60 зоорь, 42 үйлдвэр , аж ахуйн газрууд, 864 малын хашаа байранд ариутгал, халдваргүйжүүлэлт хийсэн байна. “Цагаан залаа Агвет” ХХК, ВИ ТИ НЕТ ТББ-гаас 33 нэр төрлийн 41,2 сая төгрөгийн өргөн хэрэглээний эм, багаж, хэрэгсэл зээлээр нийлүүлж мал эмнэлгийн үйлчилгээнд зарцуулсан байна.	50
98	2.3.1		"Мал эмнэлэг, үржлийн анхан	2009-2012	Аймгийн хэмжээнд мал эмнэлэг үржлийн ажил үйлчилгээ	30

	2.6		шатны үйлчилгээний нэгжийг дэмжих хөтөлбөр" боловсруулан хэрэгжүүлж, сум, дүүргийн мал эмнэлэг, үржлийн анхан шатны нэгжүүдийг бэхжүүлнэ.		явуулж байгаа 47 аж ахуйн нэгжид стандартын хэрэгжилтийг шалгахад 15 нэгж II, 32 нэгж III зэрэглэлд байгааг тогтоож, Баянхайрхан, Улиастай, Тэлмэн сумын мал эмнэлэгт машин олгож, Тэлмэн, Цэцэн-Уул, Яруу, Их-Уул сумдад шинэ байртай болголоо.	
99	2.3.1 3.3	Хөдөө аж ахуйн эдэлбэр газар ашиглах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, газрын нөөцийн болон төлөв байдлын мэдээллийн нэгдсэн сантай болох, бэлчээрийг хамгаалах, сайжруулах, усжуулах, хортон мэрэгчидтэй тэмцэх арга хэмжээг иж бүрэн авч хэрэгжүүлнэ.	4000 худаг шинээр гаргаж, 1000 худаг сэргээн засварлахад дэмжлэг үзүүлнэ.	2009-2012	Шинээр гаргах болон сэргээн засварлах худгийн судалгааг гарган жил бүр хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна. 2009 онд Усны аж ахуйн үйлдвэрлэлийн "Уст хайрхан" хоршоо, "Тэсийн бүрд" ХХК Алдархаан, Дөрвөлжин, Завханмандал, Ургамал, Сантмаргаз, Цэцэн-уул, Сонгино, Баянхайрхан, Нөмрөг, Тосонцэнгэл, Тэс, Тэлмэн, Яруу, Отгон, Цагаанхайрхан, Их-уул, Улиастай, Асгат зэрэг сумдад улсын төсвийн 261.7 сая төгрөгөөр шинээр инженерийн хийцтэй 18 худаг гаргаж 141.3 мянган га бэлчээр усжуулав. Мөн тогтвортой амьжиргаа төслийн хөрөнгөөр 7 худагт засвар хийлээ.	50
100	2.3.1 3.4		Газрын доорхи усны геофизикийн хайгуул хийж 1600 уст цэгийг шинээр тогтооход дэмжлэг үзүүлнэ.	2009-2012	Шинээр бэлчээр эзэмших зорилгоор устай цэг тогтоох судалгааг аймгийн хэмжээнд гарган яаманд хүсэлт тавьсаны дагуу 2009 онд 80,0 сая төгрөгийн хөрөнгө батлагдан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам тендер зарлан Газрын доорхи усны геофизикийн хайгуул хийх гүйцэтгэгчээр Улаанбаатар хотын "Ус-амьдрал"ХХК шалгарсан. Тус компанитай сумдын ЗДТГ хамтран 17 сумын 80 цэгт геофизикийн хайгуулыг хийлгэж тайланг ХХААХҮЯ хүлээн авсан.	50
101	2.3.1 3.5		Жил бүр 100.0 мянган га-д царцаатай, 500-гаас доошгүй мянган га-д мэрэгчтэй тэмцэх ажлыг гүйцэтгэж мал аж ахуйн үйлдвэрлэлд ашиглах бэлчээрийг нэмэгдүүлнэ.	2009-2012	ХХААХҮЯ-нд санал тавьсаны үндсэн дээр Ургамал хамгаалал хорио цээрийн албатай хамтарч үлийн цагаан огтоно тархалтын судалгааг хийж Идэр, Их-уул, Нөмрөг, Тосонцэнгэл, Түдэвтэй, Тэлмэн, Эрдэнэхайрхан, Яруу, Сонгино зэрэг 9 суманд хортон мэрэгчтэй механик, биологийн аргаар тэмцэх арга хэмжээг зохион байгуулж 35.0 мянган га бэлчээрийг сайжруулав. Энэ арга хэмжээнд улсын төсвийн 56.0 сая төгрөгийн хөрөнгийг зарцууллаа.	50
102	2.3.1 3.6		Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар хуулийн төсөл боловсруулна.	2009-2011	Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг сумдаас авч нэгтгэн Газрын харилцаа, геодези, зураг зүйн газарт хүргүүллээ.	50
103	2.3.1 4.1	Хүнс, хөдөө аж ахуйн салбарт хөдөлмөрөө хорших, хөрөнгө хүчээ нэгтгэх, хоршоо, нөхөрлөл хэлбэрээр ажиллахыг эзэл, татварын бодлогоор дэмжинэ.	"Хоршоог дэмжих хөтөлбөр" хэрэгжүүлж, мал борлуулах, түүхий эд бэлтгэх чиглэлээр сум, дүүрэг, тосгодод иргэдийн хоршоо, нөхөрлөл байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	2009-2012	Аймагт хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлийн 70 гаруй хоршоо үйл ажиллагаа явуулж байгаа нь аймгийн нийт хоршооны 50 хувийг эзэлж байна. 2009 онд 6 хоршооны үйл ажиллагааг дэмжиж 32 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олголоо.	50

104	2.3.1 6.1	Мал эрүүлжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний үнийн тарифыг шинэчилнэ.	"Мал сүргийг зарим зооноз халдварт өвчнөөс эрүүлжүүлэх хөтөлбөр" боловсруулан хэрэгжүүлж, өрх, баг, сум, дүүрэг, аймгийн түвшинд эрүүлжилтийг баталгаажуулан гэрчилгээжүүлэх арга хэмжээ авна.	2009-2012	Малын эрүүл мэнд хөтөлбөрийг амжилттай зохион байгуулснаар хорогдсон малд өвчний хорогдол 3.3 хувь болж 2008 оноос 6.4 хувиар буурав. Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2008 оны 60 дугаар тогтоолоор баталсан жишиг үнийг мал эмнэлэг үржлийн ажил үйлчилгээ гүйцэтгэхэд мөрдөн ажиллаж байна.	50
105	2.3.1 7.1	Хөрсний эвдрэлтэй тэмцэх шинэ технологи ашиглан атаршсан талбайг тариалангийн зориулалтаар сэргээн ашиглах ажлыг эрчимжүүлнэ.	Байгаль экологид сөрөг нөлөөгүй дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх замаар өнжөөсөн болон атаршсан талбайг эргэлтэд оруулна.	2009-2012	"Тэсийн гол" ХХК-д техник тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж 192 га атаршсан талбайд боловсруулалт хийж үр тариа тарьж 118 тн ургац хураан авлаа.	30
106	2.3.1 7.2		Тэг болон цомхотгосон аргаар бэлтгэх уриншийн хэмжээг 50.0 мянган га талбайд хүргэнэ.	2009-2012	Алдархаан сумын шар талын услалтын системийг түшиглэн 200 га талбайд уринш хийлээ.	30
107	2.3.1 8.1	Хүлэмжийн ногоо болон жимс, жимсгэний аж ахуйг дэмжинэ.	Зоорь, агуулахын төрөлжсөн аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэн, томоохон хотуудад хүнсний нарийн ногооны төрөлжсөн бөөний худалдааны зах, биржийн тогтолцоо бүрдүүлнэ.	2009-2012	Аймгийн хэмжээнд 35 аж ахуйн нэгж, 120 өрхөд 3398.7 тн-ын багтаамж бүхий 157 зоорь ашиглагдаж байна. Улиастай суманд, төмс хүнсний ногооны 2 төрөлжсөн зах ажиллаж байна.	30
Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдлын бодлогын хэрэгжилт						35
2.4 Дэд бүтэц хот байгуулалтын бодлого						
108	2.4.5. 2	Газар ашиглалтыг сайжруулж, газрын шинэтгэлийг эрчимжүүлэн Монгол Улсын иргэн бүрт газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулна.	Монгол Улсын иргэн бүрт үнэгүй өмчлүүлэх боломжтой газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоож, газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулна.	2009-2012	Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх ажлыг шат дараатайгаар төлөвлөн ажилласны үндсэн дээр аймгийн хэмжээнд газар өмчлөлийн үйл ажиллагаа 41 хувьтай явагдаж 2010 онд аймгийн хэмжээнд иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр өмчлүүлэхээр 625 иргэнд 206.35 га газрыг, одоо эзэмшиж байгаа хашааны газрыг өмчлүүлэхээр 1236 иргэнд 109.02 га газрыг тус тус өмчлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Одоогийн байдлаар аймгийн төв Улиастай хотод 174 иргэнд аймгийн Засаг даргын 2010 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 06 тоот захирамж, Тосонцэнгэл суманд 7 иргэнд, Их-Уул суманд 3 иргэнд тус тус газар өмчлүүлэх тухай захирамж гарч газар өмчлөлийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Цаашид аймгийн ГЗБЕТөлөвлөгөө болон ТЖГЗБТ-г хэрэгжүүлэх, газар өмчлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр аймгийн ГХБХБГазар төлөвлөгөө гарган ажиллаж байгаагийн зэрэгцээ Монголын мянганы сорилтын сангийн Хөрөнгийн эрхийн төсөл хөтөлбөртэй	50

					хамтран ажиллаж уг төслийг Улиастай сумын хэмжээнд хэрэгжүүлэхээр болоод байна.	
109	2.4.5.3		Нийслэлийг аймгийн төвүүдтэй холбосон улсын чанартай авто замын дагуу иргэдэд өмчлүүлэх боломжтой газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоож, өмчлүүлэх ажлыг зохион байгуулна.	2009-2012	Улсын чанартай авто замын дагуу иргэдэд өмчлүүлэх боломжтой Завхан аймгийн Идэр, Тэлмэн, Тосонцэнгэл, Их-Уул, Алдархаан зэрэг сумдын нутаг дэвсгэрт сууришлын бүс үүсгэн өмчлүүлэх газрын судалгааг гарган ГХБГЗЗГазарт хүргүүлж, тухайн газарт уг ажлыг зохион байгуулахад шаардагдах нарийвчилсан судалгааг хийж байна.	30
110	2.4.5.4		Аж ахуйн болон гэр бүлийн хэрэгцээнд зориулан өмчлүүлэх газар тариалангийн болон эрчимжсэн фермерийн аж ахуйн зориулалтын газрын хэмжээ, байршлыг тогтоон, өмчлүүлэх ажлыг зохион байгуулна.	2009-2012	Аж ахуйн болон газар тариалангийн зориулалтаар давуу эрхээр нийт 4 иргэнд 1.61 га газрыг, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 2207 иргэнд 299.51 га газрыг тус тус өмчлүүлсний зэрэгцээ 2010 онд иргэн аж ахуйн нэгж, байгууллагад аж ахуйн зориулалтаар 1884 иргэнд 321.47 га газрыг, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 1861 иргэнд 315.37 га газрыг өмчлүүлэхээр газрын хэмжээ, байршлыг тогтоон аймгийн ИТХ-аар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	50
111	2.4.6.5	GPS-ийн технологийг нэвтрүүлэх, Монгол Улсын GPS-ийн сүлжээ байгуулах 2 дахь шатны ажлыг хийж, өндрийн сүлжээг сайжруулна.	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хилийн цэсийг эргэлтийн цэгийн солбицлуудаар тодорхойлон баталгаажуулах ажлыг шат дараатай хийж, солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлнэ.	2009-2012	Улсын болон засаг захиргааны нэгжийн хилийн шугамыг GPS-ийн солбицлоор тоон хэлбэрт оруулах ажлын хүрээнд аймгийн хэмжээнд одоогийн байдлаар Говь-Алтай, Увс аймгийн хилийн шугамын зарим хэсгийн дагуу хилийн цэсийг эргэлтийн цэгийн солбицлуудаар тодорхойлон баталгаажуулах ажлыг хийж байна.	30
112	2.4.7.1	Нийслэл болон орон нутагт 100.0 мянган айлын орон сууц барих төсөл боловсруулж хэрэгжүүлнэ. Бага, дунд орлоготой иргэдийг орон сууцжуулах бодлогод ахиц дэвшил гаргана.	Шинэ хотхон, хорооллыг барих ажлын хүрээнд 37.0 мянган орон сууц барина.	2009-2012	Улиастай-200 орон сууцны дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж, 20, 30 айлын орон сууцны гадна инженерийн шугамыг шинээр хийж, 1-р уурын зуухны гадна дулааны шугамыг шинэчиллээ. Улиастайд бага дунд орлоготой залуу гэр бүлд зориулсан 30 айлын, орон сууц ашиглалтанд орлоо. Төрийн албан хаагчдын 20 айлын орон сууц энэ онд ашиглалтад орно. Их-Уул суманд 2008 онд 8 айлын орон сууц ашиглалтанд орууллаа. 2010 онд аймгийн төвд 20 айлын орон сууц шинээр барихаар төлөвлөж техник эдийн засгийн үндэслэл, техникийн нөхцөл, зураг төслийг бэлэн болгож ОССК-д хүргүүлсэн хөрөнгийн асуудал шийдэгдэхгүй байна. Тосонцэнгэл сумд 8 айлын орон сууц баригдаж байна.	50
Дэд бүтэц хот байгуулалтын бодлогын хэрэгжилт						42
2.5 Орон нутгийн хөгжлийн бодлого						
113	2.5.2.2	Сумдад жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор 50.0 саяас доошгүй төгрөгийн эх	Баг бүрийг өрхийн амьжиргааг дэмжих, ядуурлыг бууруулахад чиглэгдсэн 1.0 саяас доошгүй төгрөгийн эх үүсвэртэй, эргэн	2009-2012	Багийн хөгжлийг дэмжих, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх зорилгоор нутгийн зөвлөл, иргэдийн хандивийн хөрөнгөөр аймгийн 40 багт 200-500,0 мянган төгрөгийн санг бүрдүүлээд байна.	30

		үүсвэртэй “Үйлдвэрлэл хөгжүүлэх сан” байгуулж ажиллуулна.	төлөгдөх нөхцөл бүхий хөгжлийн сантай болгоно.			
114	2.5.3.6	Эрчим хүчний төрөл бүрийн эх үүсгүүрийг ашиглан бүх сумыг байнгын цахилгаантай болгож, багийн цахилгаан хангамжийг сайжруулна. Аймаг, орон нутгийн дулаан хангамжийн системийг сайжруулж, хүчин чадлыг нь нэмэгдүүлнэ.	Аймгийн төвүүдийн дулаан хангамжийн байдалд судалгаа хийж, шинэчлэлтийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна.	2009	ШУТИС, ЭХИСургууль дулааны хэрэглээний дэвшилтэд техник, технологийн судалгааны төв хамтран аймгийн төв болон сумдын дулаан хангамжийн системийг боловсронгуй болгох талаар судалгаа хийж, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж байна. Их-Уул сум Хөвсгөл айгийн Жаргалант сумаас төвийн эрчим хүчний нэгдсэн системээс 24 цагийн эрчим хүчээр хангагдаж байна. Цагаанхайрхан, Алдархаан сумд Улиастай сумын айл өрхийн нэгэн адил эрчим хүчээр хангагдан бусад 16 сум дизель цахилгаан станцаар өдөрт дунджаар 4-5 цаг эрчим хүчээр хангагдаж байна. Эдгээр 17 сумдыг цахилгаан эрчим хүчээр хангахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг “Эрчимтэй хөгжил Завхан” сангаас санхүүжүүлж байна. Отгон, Нөмрөгийн дотоод цахилгаан дамжуулах агаарын шугамын 0.4кВ-ын шугам нь 1970-аад оноос хойш урсгал болон их засвар хийгдээгүйн улмаас бетон шон, шонгийн мод зэрэг нь илжирч муудан шугам сүлжээ нь байхгүй болсон. Тэс сум Увс аймгийн Зүүнхангай сумтай холбогдсоноор 24 цагийн цахилгаан эрчим хүчээр хангагдаж байна.	50
115	2.5.3.7		Аймгийн төвийн дулааны станц, дулаан хангамжийн системийн харъяалал, өмчийн хэлбэр, шугам сүлжээний хил заагийг тогтоож, дулаан хангамжийн зуух, тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчлэх, халаалтын доголдлыг бүрэн арилгаж, хэрэгцээний халуун усны системтэй болгон ард иргэдийн амьжиргааны таатай нөхцөлийг бүрдүүлнэ.	2009-2012	Германы техник хамтын ажиллагааны нийгэмлэгийн хөрөнгө оруулалтаар Санмин нөхөрлөл халаалтын зуухын тоног төхөөрөмжийг бүрэн шинэчиллээ. Мөн 2-р 60 айлын орон сууцны нэг орцыг дээрх төслийн хөрөнгө оруулалтаар хэрэглээний халуун устай болгосон. Цаашид төвлөрсөн орон сууцуудыг хэрэглээний халуун устай болгох талаар судалгаа хийж, төлөвлөрсөн орон сууцуудыг хэрэглээний халуун устай болгох зорилт тавин ажиллаж байна.	30
116	2.5.4.1	Өрх бүрийг цахилгаан эрчим хүчний эх үүсвэртэй болгоно.	Улсын төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сан болон дотоод, гадаадын хөрөнгө оруулалтаар цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний өргөтгөл, засвар, шинэчлэлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	2009-2012	Улсын төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх санийн хөрөнгө оруулалтаар сумдын 10кВ, 35кВ, 110кВ-ын ЦДАШ, Дэд станцуудын барилгын ажил хийгдсэн боловч цахилгааны эх үүсвэргүйн улмаас улсын комисс-д хүлээлгэн өгөөгүй байна. ГТХАН-ийн Сэргээгдэх эрчим хүчний төслийн хөрөнгө оруулалтаар 800 сая төгрөгөөр Сантмаргац, Завханмандал, Цэцэн-Уул, Сонгино, Эрдэнэхайрхан сумдын дотоодын 0.4кВ-ын агаарын шугамын шинэчлэлтийн ажлыг хийж, Мөн Галуутай, Гацааны УЦС-уудыг ашиглалтанд орууллаа. Одоо ДХБ-ны Төслийн	50

					хүрээнд Ургамал, Дөрвөлжин сумдын 0.4кВ-ын шугамын шинэчлэлтийг хийж, нарны сэргээгдэх эрчим хүчээр хангахаар барилгын ажил нь хийгдэж байна. Одоо Отгон, Нөмрөг сумдаас бусад сумд 5-6 цагаар эрчим хүчээр хангагдаж байна.	
117	2.5.6.3	Орон нутагт барилгын материалын болон боловсруулах үйлдвэрийг шинээр байгуулна.	Орон нутгийн эрдэс, түүхий эдийн нөөцөд тулгуурлан бүс нутгуудад бетон, төмөр бетон, дуу чимээ, дулаан тусгаарлах болон ханын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.	2009-2012	Орон нутгийн барилгын материалын түүхий эдэд тулгуурлан барилгын материалын үйлдвэрлэл эрхэлдэг 8 аж ахуйн нэгж тоосго, хүрмэн, нүхтэй блок, замын хавтан, бродюр, төмөр бетон хийц, вакуум цонх үйлдвэрлэн орон нутгийн хэрэгцээнд нийлүүлж байна. Мөн эрдэс баялгийн нөөцийн судалгаанд тулгуурлан барилгын материалын үйлдвэрлэл шинээр нэмж байгуулах саналыг боловсруулан холбогдох газруудад хүргүүлэн ажиллаж байна.	50
118	2.5.7.2	Алслагдсан болон говийн бүсийн нэмэгдэл олгох оновчтой хэлбэрийг буй болгоно.	Алслагдсан болон говийн бүсийн байгалийн хүнд нөхцөлд амьдарч, ажиллаж байгаа иргэдэд нийгмийн хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлэх асуудлыг судалж шийдвэрлэнэ.	2011-2012	Хугацаа болоогүй	
119	2.5.9.1	Сургуулийн дотуур байр, эмнэлэг, соёлын төвийг шинээр барих буюу өргөтгөж засварлана.	Сургуулийн дотуур байр, эмнэлэг, соёлын төвийг шинээр барих буюу өргөтгөж засварлах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.	2009-2012	Цагаанхайрхан, Отгон сумдын эмнэлгийн барилгын ажил дуусаж ашиглалтанд орсон. 2009 онд Их-Уул, Отгон, Эрдэнэхайрхан сумдын соёлын төвүүдийн засварт төсвөөс 10.9 сая, төсөл хөтөлбөрийн хүрээнд 50.4 сая төгрөгийн сандал, гэрэлтүүлэг, техник хэрэгсэл нийлүүлсэн байна. Тосонцэнгэл сумын I сургуульд 640 хүүхдийн, Түдэвтэй, Их-Уул суманд тус бүр 320 хүүхдийн суудалтай хичээлийн байрыг барьж эхлээд байна. Эрдэнэхайрхан сумын спорт заалны барилгыг барьж дуусгах, Сантмаргац, Идэр, Нөмрөг, Яруу сумдын хичээлийн байр, спорт заалны засварт нийт 829,9сая төгрөгийн засварын ажил хийгдэж ашиглалтанд орсон байна. Сантмаргац сумын 80 хүүхдийн дотуур байрын их засвар 310 сая төгрөгийн, Идэр сумын хичээлийн байр, спорт заалны барилгын их засварын ажил 140 сая төгрөгний төсөвт өртөгтэйгөөр чанартай сайн хийгдэж ашиглалтанд орлоо.	50
120	2.5.10.1	Атрын 3 дахь аяны хүрээнд тухайн аймгийн нутагт бүрэн ашиглагдаагүй байгаа тариалангийн талбайг ашиглан тариалан эрхэлж, газар тариалангийн техникийн паркийг шинэчилнэ.	"Атрын 3 дахь аян" тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд газар тариалангийн техник, технологийн парк шинэчлэх ажлыг хэрэгжүүлж өндөр хүчин чадалтай трактор 725, үр тарианы комбайн 550-ийг нийлүүлнэ.	2009-2012	Газар тариалангийн техник, тоног төхөөрөмжид шинэчлэл хийж "Нарантуул-Тэс"ХХК-д үр тарианы үйлдвэрлэлтийг зориулалтаар комбайн болон том оврын тракторыг иж бүрдлийн хамт, мөн Тэлмэн суманд МТЗ-82 маркын трактор, Улиастай сумын "газрын шим" хоршоонд дундын үйлчилгээний зориулалтаар дунд бага оврын 6 тракторыг нийлүүлэв.	30

Орон нутгийн хөгжлийн бодлогын хэрэгжилт						41
3. Байгаль орчин аялал жуулчлалын бодлого						
121	3.2.1	Түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлах, нүүрсийг боловсруулах, гэр хорооллыг орон сууцжуулахад зориулж инженерийн байгууламжийг өргөтгөх, ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх, нийтийн тээврийг шинэчилж хийн түлшинд шилжүүлэх замаар Улаанбаатар болон бусад хотуудын агаарын бохирдлыг бууруулна.	Агаарын бохирдлыг бууруулах, чанарыг хангах эрх зүйн орчныг шинэчилж, агаарын бохирдлыг бууруулах талаар хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	2009-2010	Агаарыг хамгаалах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа. Хөтөлбөрийн хүрээнд агаар бохирдуулагч хөдөлгөөнт болон суурин эх үүсвэрийн тооллого хийх, уурын зуухнуудад шалгалт хийж утааг шүүх шүүлтүүр тавьж бохирдлыг бууруулах албан шаардлага өгч, Улиастай сумын агаарын бохирдлын хяналт шинжилгээг оргил хугацаанд хэд хэдэн цэгт хэмжиж бохирдлыг бууруулах арга хэмжээг авлаа. Агаар дахь хүхэрлэг хийн жилийн дундаж агууламж агаарт байж болох хүлцэх агууламжаас хэтэрсэн тохиолдол ажиглагдаагүй байна.	50
122	3.2.4		Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас агаарт гаргах тоосонцрын хаягдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2009-2012	Улиастай хотын халаалтын зуухнуудад БОНБЕҮнэлгээг хийж, нөхцөл болзол, шаардлагыг гарган, хэрэгжүүлэх арга хэмжээ авч, агаарын чанарын алба байгуулан ажиллаж байна.	30
123	3.3.2	Хот суурин газрууд дахь агаар, ус, хөрсний бохирдлыг багасгаж, иргэдийн ажиллаж амьдрах эрүүл орчныг бүрдүүлнэ.	Томоохон хот суурин газрын цэвэрлэх байгууламжид техник, технологийн шинэчлэл хийж, ашиглалтыг сайжруулан, стандартын шаардлага хангуулна.	2009-2012	Улиастай сумын цэвэрлэх байгууламжийн хаягдал усны цэвэрлэгээний түвшин, үйлдвэрлэлийн технологид байнгын хяналт тавин ажиллаж байна. Цэвэрлэх байгууламжид шинэчлэлт хийх төсөв төлөвлөгөөг боловсруулж байна.	10
124	3.4.2	Хот, суурин газруудад хог хаягдлын шинэ менежментийг нэвтрүүлж, хог боловсруулах үйлдвэр байгуулна.	Бүх аймгуудын хатуу хог хаягдлын мастер төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.	2009-2012	Аймгийн хог хаягдлыг бууруулах мастер төлөвлөгөө боловсруулах судалгааны ажил хийгдэж төлөвлөгөөг ойрын хугацаанд батлуулахаар ажиллаж байна. 2010 оныг сумдын бүтээн байгуулалт тохижилтийн жил болгон зарласантай холбогдуулан сумдын хатуу хог хаягдал, хогийн цэгийг булж зайлуулахаар үндсэн чиглэлд тусгаад байна.	30
125	3.4.4		Бүсийн тулгуур төв хотуудад хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр байгуулах, томоохон хот, суурин газрын хог хаягдлын төвлөрсөн цэгийг тохижуулж, хог хаягдлыг булшлах ландшафллийн аргыг нэвтрүүлнэ.	2009-2012	Улиастай сумын хог хаягдлын цэгт 5 га талбайг хашиж, ландшафт байгуулаж ажлыг хийж байна. Хуванцар сав, гялгар уут боловсруулах жижиг үйлдвэрийг мөн байгуулж байна. Улиастай сумын иргэн Д.Сүхбаатарын Хог хаягдал боловсруулах үйлдвэр байгуулах төслийг дэмжиж 14.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон. Мөн үндсэн чиглэлд тусгаснаар бүх сумдын хогийн цэгийг зайлуулах, булах арга хэмжээ авахаар төлөвлөөд байна.	30
126	3.5.2	Усны талаархи төрийн	Гол, мөрний сав газрын	2009-2012	Сум дамжин урсдаг Идэр, Хүнгийн голын сав газрын	30

		нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, гол мөрний урсацад тохируулга хийх, хуримтлагдсан усны нөөцийг шилжүүлэн ашиглах дэд бүтцийг байгуулна.	зөвлөлүүдийг байгуулан ажиллуулж, сав газрын усны менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.		зөвлөлийг Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчийн тогтоолоор байгуулан ажиллуулж байна. Бусад голуудын сав газрын зөвлөлийг байгуулах болон усны менежментийн төлөвлөгөө боловсруулах судалгааны ажлыг хийж байна.	
127	3.5.10		Усан сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг шинэчлэн тогтоож, дэглэмийг мөрдүүлнэ.	2009-2010	Бүх сумдын Засаг дарга, байгаль орчны хяналтын байцаагч, байгаль хамгаалагчдад усан сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрт хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоох талаар сургалт явуулж суурин газруудад дэглэмийг мөрдүүлэх ажлыг зохион байгуулж байна.	50
128	3.6.1	Говь, хээрийн болон цөлжилт ихээр явагдаж байгаа бүсүүдэд унаган ургамлыг тарималжуулах, хур тунадас нэмэгдүүлэх, ус хуримтлуулах, хиймэл нуур, цөөрөм байгуулах замаар экосистемийн тэнцвэрт байдлыг хангах арга хэмжээ авч, "Ус" хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Гадаргуугийн урсац, хур тунадасны усыг хуримтлуулах замаар усан сан болон хөв, цөөрөм байгуулж бэлчээр, хадлан, тариалангийн талбайг усжуулах, ногоон байгууламжийн усалгаанд ашиглах аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагааг дэмжинэ.	2009-2010	Алдархаан сумын Харганы аманд бороо цасны усыг хуримтлуулах хөв байгуулах төслийг хийж Усны газарт хүргүүллээ. Мөн сумдын байцаагч, байгаль хамгаалагч нарт хөв байгуулах зөвлөмж өглөө.	30
129	3.6.2		Ойжуулах, мод, бут, сөөг, загийг үрээр тарималжуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор иргэд, аж ахуйн нэгжийн төсөл, арга хэмжээг санхүүгийн болон бусад хэлбэрээр дэмжинэ.	2009-2010	Суурин газрыг цэцэрлэгжүүлэх, тариалангийн талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулах, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын жимсний мод бут тарих ажлыг дэмжиж үр, тарьц суулгацаар хангах, арга зүйн зөвлөгөө өгөх, Ойжуулах, мод, бут, сөөг, тарих, иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх 2 гарын авлагыг гарган нийтэд сурталчилах зэрэг ажлыг хийж байна. Мөн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор бүх нийтэд хандсан уриалга гарган орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах, уралдааны болзол зарлаж дүгнэн урамшуулах зэрэг арга хэмжээ авч ажилласны дүнд төв сууринг цэцэрлэгжүүлэх ажлын хэмжээ нэмэгдэж 2009 онд 17,0 мянган ширхэг мод тарьж ургуулж байна.	70
130	3.7.1	Говь, хээрийн бүсийн бэлчээрийг усжуулах зориулалтаар баг бүрт нар, салхины эрчим хүчээр ажиллах тус бүр нэг худаг гаргана.	Бэлчээрийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэн, говь, хээрийн бүсийн усны нөөцийн судалгааг явуулж, уст цэг гаргах дүгнэлт гарган баг бүрт нар, салхины эрчим хүчээр ажиллах тус бүр нэг худаг гаргана.	2009-2012	Ногоон алт хөтөлбөрийн газартай хамтран бэлчээрийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу бэлчээрийн төлөв байдлыг нарийвчлан тогтоох судалгааны ажил, уст цэгийн судалгаа, шинээр бэлчээр эзэмших газрын судалгаа зэргийг гарган ажиллаж байна.	30
131	3.9.1	Хөрс хамгаалах эрх зүйн	"Атрын 3 дахь аян"-ыг хэрэгжүүлэх	2009-2010	"Атрын 3 дахь аян"-ы хүрээнд Алдархаан сумын Шар	30

		үндсийг боловсронгуй болгож, Хөрсний тухай хууль гаргаж хэрэгжүүлнэ.	ажлын хүрээнд ойн зурвас бүхий тариалан эрхлэлтийг урамшуулах, дэмжих бодлого хэрэгжүүлнэ.		талын усалгаатай тариалангийн талбайд 13 га талбайд салхинаас хамгаалах ногоон зурвасыг байгуулж байна.	
132	3.14.2	Монгол орны экосистемийн тэнцвэрт байдлыг хангахад онцгой ач холбогдол бүхий улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлнэ.	Орон нутгаас тусгай хамгаалалтад авах газар нутгийн шалгуур үзүүлэлт, үндэслэлийг шинэчлэн тогтоож, бүртгэл тооцоог Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн нэгдсэн сүлжээнд хамруулна.	2009-2010	Эрдэнэхайрхан, Цэцэн-уул, Сантмаргац, Завханмандал сумдын нутгийг хамарсан Хүнгүйн Хар нуур, Улаагчны Хар нуурын орчмын 253.8 мян.га, Алдархаан сумын Монгол элсний орчмын 100 гаруй мянган га газар нутгийг улсын тусгай хамгаалалтанд авахуулахаар саналыг БОАЖЯ-д хүргүүлсний үндсэн дээр УИХ-ын 2010 оны 06 тоот тогтоолоор улсын тусгай хамгаалалтанд авахууллаа. Сумдын Засаг дарга, ЗДТГ-ын дарга нар, байгаль орчны хяналтын байцаагч, байгаль хамгаалагчдад газар нутгийг орон нутгийн хамгаалалтанд авах талаар 3 удаагийн сургалтыг зохион байгуулсан.	50
133	3.14.8		Тусгай хамгаалттай газар нутгийн байгаль орчны төлөв байдалд үнэлгээ хийж, дүгнэлт гарган тухайн газрын онцлог, нөөц даацад тохируулан аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах арга зүйг боловсруулан мөрдүүлнэ.	2009-2010	Тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулж буй аялалын жуулчлалын байгууллагуудын үйл ажиллагаанд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийж, арга зүйн зөвлөгөө өгсний үндсэн дээр үйл ажиллагааг нь явуулж байна.	50
134	3.15.4	Ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх тогтвортой менежментийг бий болгож, мод орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл, модны хэрэглээг импортоор хангах санаачилгыг дэмжинэ.	Нэн тэргүүнд ойжуулах, нөхөн сэргээх шаардлагатай газрыг тодорхойлж, нийтэд зарлан, жилд 10,0 мянган га-аас доошгүй талбайг ойжуулж, нөхөн сэргээнэ.	2009-2010	Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг гүйцэтгэх аж ахуйн нэгжийг тендер зарлан шалгаруулж За-Шинэстэй ХХК, Дядан ХХК, Эрдэнэбаян тэгш ХХК-аар 414 га ойжуулалт, 30 га байгалийн сэргэн ургалтанд туслах ажлыг гүйцэтгүүлэн хүлээн авлаа. Мөн Хан хөвч, Харнагат, Газар далай, Жам, Товгорын нуруу, Их ёл ХХК-ууд нийт 41 га-д ойжуулалт, Сайхан ой ХХК 10 га-д байгалийн сэргэн ургалтанд туслах ажлыг байгууллагын өөрийн хөрөнгөөр гүйцэтгэсэн.	50
135	3.15.9		Хууль бусаар мод бэлтгэхтэй тэмцэх, хянах үйл ажиллагааг орчин үеийн технологи ашиглан боловсронгуй болгож, орон нутгийн ойн байгууллага болон нутгийн иргэдийн оролцоонд түшиглэн тэмцэнэ.	2009-2012	Ойн ашиглалтын хамгийн их нөөц бүхий Тосонцэнгэл суманд сум дундын ойн ангийг байгуулж, мэргэжлийн байгууллагууд болон иргэдийн нөхөрлөл, ТББ зэрэгтэй хамтран Ойн тухай болон Байгаль орчны хууль зөрчигчидтэй тэмцэж байна.	30
136	3.16.4	Амьтан, ургамлын нөөцийг хамгаалах, зохистой ашиглах менежментийг сайжруулж, тэдгээрийн байгалийн жамаар өсөж үржих, нөхөн сэргэх таатай	Ховордсон амьтныг хамгаалах ажлыг сайжруулж, мазаалай баавгай, хавтгай тэмээ, баданга хүдэр, монгол бөхөн, буган цаа, голын халиу, хар мөрний хилим зэрэг нэн ховор амьтдыг идээшил нутагт нь өсгөн үржүүлэх,	2009-2012	Ховор ан амьтныг өсгөн үржүүлэх, хамгаалах зорилгоор Аймгийн Засаг дарга, сумдын Засаг дарга нартай байгуулсан гэрээнд биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасны дүнд 8 сумдад /Сонгино, Цэцэн-Уул, Баянтэс, Баянхайрхан, Нөмрөг, Идэр, Түдэвтэй, Дөрвөлжин сумдад/ нийт 5300 кг хужир, 2895 кг өвс бэлтгэж аргал, буга, бор гөрөөс, янгир ямаа нутагладаг	50

		нөхцөлийг бүрдүүлнэ.	тэдгээрийн генийн санг хамгаалахад биотехнологийн ололтыг ашиглана.		газраар тавьж өгөх, сурагчдын дунд байгаль хамгаалах клуб байгуулан ажиллуулах, ан амьтанг хууль бус агналтаас сэргийлэх сурталчилгааны ажлыг зохион байгуулах зэрэг ажлыг хийж байна.	
137	3.17.3	Монгол Улсын газрын талаархи төрийн бодлого, газрын нэгдмэл сангийн оновчтой төлөвлөлтөд үндэслэсэн байгаль орчныг хамгаалах, газар, түүний хэвлийн баялгийг зохистой ашиглан хамгаалах нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, газрын болон эд хөрөнгийн бүртгэлийн өнөөгийн тогтолцоог өөрчлөн бие даасан бүтэц бий болгож, газар зохион байгуулалт, газрын үнэлгээний аргачлалыг шинэчлэн мөрдүүлнэ.	Газрын нэгдмэл сангийн тайлангийн өгөгдлүүдийг боловсронгуй болгох, түүнд газрын ангиллын шилжилт, хөдөлгөөнийг байнга тусгах, байгаль орчны даац, чадавхид нийцүүлсэн газар зохион байгуулалтын урт хугацааны менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.	2009-2012	Аймгийн газрын нэгдмэл сангийн нэгдсэн тооллогыг 2006 онд мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн ба газрын ангилалын шилжилт хөдөлгөөнийг цаг тухайд нь атрибут мэдээлэлтэй нь холбож тухай жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд байгаль орчин болон бэлчээрийн менежментийн талаар тусган ажиллаж байна.	30
138	3.17.5	бодлогыг хэрэгжүүлж, газрын болон эд хөрөнгийн бүртгэлийн өнөөгийн тогтолцоог өөрчлөн бие даасан бүтэц бий болгож, газар зохион байгуулалт, газрын үнэлгээний аргачлалыг шинэчлэн мөрдүүлнэ.	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгөөр дамжуулан байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.	2009-2012	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний үндсэн дээр тус аймгийн ГЗБЕТөлөвлөгөө боловсрогдон гарсан бөгөөд байгаль орчныг хамгаалах нөөцийг зохистой ашиглах нөхөн сэргээх арга хэмжээг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Аймгийн ГХБХБГ нь 2010 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 332 га газрыг элэгдэл, эвдрэл, доройтлоос хамгаалах, цэцэгжүүлэх, нөхөн сэргээх талаар тусган ажиллаж байна. Үүнд: Алдархаан, Их-Уул, Идэр, Тосонцэнгэл, Тэлмэн зэрэг сумдад 320 га газарт ойжуулалт, Улиастай сумын Жинст, Богдын гол багуудын 20 га газарт ногоон байгууламж хийх, Завханмандал суманд 10 га газарт ойн зурвас байгуулахаар төлөвлөөд байна.	30
139	3.18.2	Аялал жуулчлалын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, жуулчлалын бүсийн дэд бүтцийг сайжруулах замаар жуулчдын тоог нэмэгдүүлнэ.	"Аялал жуулчлалын үндэсний хөтөлбөр" боловсруулж хэрэгжүүлнэ.	2009-2012	Баруун бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр, Аялал жуулчлалын аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан батлуулж хэрэгжилтийг зохион байгуулах төлөвлөгөөг жил бүр гарган ажиллаж байна.	50
140	3.18.3	Аялал жуулчлалын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, жуулчлалын бүсийн дэд бүтцийг сайжруулах замаар жуулчдын тоог нэмэгдүүлнэ.	"Аялал жуулчлалын маркетингийн стратеги төлөвлөгөө" боловсруулж, Монгол Улсыг нэгдсэн бодлоготойгоор гадаадад сурталчлах ажлыг зохион байгуулна.	2009-2012	Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын ажилтнуудад сургалт зохион байгуулан, орон нутгийг гадаад дотоодод сурталчлах веб сайтыг интернетэд байршуулан мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллуулж байна. Түүх соёлын дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газруудын судалгаа гарган нийтэд сурталчлах, сурагчдын дунд тойрон аялал зохион байгуулах, "Отгонтэнгэрийн орноор" цуврал нэвтрүүлэг бэлтгэх зэрэг ажлуудыг зохион байгуулаад байна. Отгонтэнгэрийн орноор нэвтрүүлгийн бэлтгэл ажил дуусч Боловсрол суваг телевизээр орон даяар цацагдаж байна.	50
141	3.18.4	Аялал жуулчлалын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, жуулчлалын бүсийн дэд бүтцийг сайжруулах замаар жуулчдын тоог нэмэгдүүлнэ.	Аялал жуулчлалын мэдээллийн сан бий болгож, салбарын статистик	2009-2010	Аялал жуулчлалын ач холбогдол бүхий газар нутгийн судалгаа, аялал жуулчлалын байгууллагуудын	30

			бүртгэлийг сайжруулна.		мэдээллээр сан байгуулан ажиллаж байна. Дээрх мэдээллийн санд орсон мэдээллүүдээр аялал жуулчлалын гарын авлага хэвлүүлэн гаргалаа.	
142	3.18.5		Жуулчин тээвэрлэх, хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэн, салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхийг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, аялал жуулчлалын үйлчилгээний чанарыг олон улсын жишигт ойртуулна.	2009-2012	Жуулчин тээвэрлэх жолооч нар, зоогийн газар, зочид буудал зэрэг үйлчилгээний газруудын ажилтнуудад үйлчилгээний стандарт, чанарыг сайжруулах сургалтуудыг зохион байгуулж байна. Мөн аймгийн төвд жуулчдыг хүлээн авах, тэдэнд ая тухтай орчин бүрдүүлэх зорилгоор Улиастай зочид буудалд бүрэн засвар хийж ашиглалтанд орууллаа. Хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор Завхан аймаг дахь Эдийн засгийн салбар сургууль дээр аялал жуулчлалын ангийг нээн хичээллүүлж эхлээд байна.	50
143	3.18.6		Аялал жуулчлалын томоохон цогцолбор барьж байгуулна.	2009-2010	Аялал жуулчлалын цогцолбор байгуулах судалгааны ажлыг хийж байна.	10
144	3.18.7		Түүх, соёлын болон адал явдалт, тусгай сонирхлын аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлж, аялал жуулчлалын эвент, арга хэмжээнүүдийг зохион байгуулах ажлыг дэмжинэ.	2009-2012	Сум бүр өөрийн онцлогт тохирсон эвент, арга хэмжээг бий болгох ажлыг зохион байгуулж байна. Улаанбаатар хотод зохион байгуулагдаж буй Олон Улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд аймгийг сурталчилах, веб сайт нээн аялал жуулчлалын ач холбогдол бүхий газар нутгийг сурталчлах, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудад аялалын төрлүүдийг хөгжүүлэх зөвлөмж өгөх зэргээр ажиллаж байна. Мөн аймгийн байгалийн үзэсгэлэнт газрууд жуулчны бааз, зочид буудлуудын мэдээллийг багтаасан гарын авлагыг хэвлэн гаргалаа.	30
145	3.19.2	Байгаль орчны төрийн хяналтыг сайжруулан, байгалийн нөөц баялгийн халдашгүй байдлыг хангах үүрэг, хариуцлагыг чангатгана.	Байгалийн нөөц баялгийг хамгаалах, зохистой ашиглахтай холбогдуулан аймаг, сумын Засаг даргын үүрэг, хариуцлагыг өндөржүүлнэ.	2009-2012	Аймгийн Засаг даргын сумдын Засаг дарга нартай бүтээгдэхүүн нийлүүлэх талаар байгуулах гэрээнд байгалийн нөөц баялгийг хамгаалах, зохистой ашиглах, түүнд тавих хяналт, үүрэг хариуцлагыг өндөржүүлэх талаар даалгавар өгч биелэлтийг тооцон ажиллаж байна.	30
146	3.19.3		Ашигт малтмал олборлосон эдэлбэр газрыг нөхөн сэргээх стандартыг баримтлан хяналт, хариуцлагын механизмыг боловсронгуй болгоно.	2009-2012	Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажилд тавих хяналтыг сайжруулан ажиллаж байна. Тус аймагт ашиглалтын 3 тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжтэй боловч одоогоор олборлох үйл ажиллагааг явуулаагүй байна.	10
147	3.19.4		Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, үйлчилгээнд тавих байгаль орчны болон олон нийтийн хяналтыг сайжруулна.	2009-2012	Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, үйлчилгээнд тавих хяналтыг ТББ, иргэдийн нөхөрлөлтэй хамтран зохион байгуулж байна. Иргэдийн нөхөрлөлтэй хамтран аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй уурын зуухнуудад шалгалт хийж стандартын шаардлага хангахгүй уурын зуухнуудад албан шаардлага хүргүүлээ.	30
Байгаль орчин аялал жуулчлалын бодлогын хэрэгжилт						36
4.1 Эрх зүйн бодлого						

148	4.1.3.2	Батлагдсан хууль тогтоомжийг төв, орон нутагт цаг алдалгүй хүргэх, эрх зүйн албан бус сургалтыг мэргэжлийн үндсэн дээр зохион байгуулах ажлын цар хүрээ, хүртээмж, чанар, үр нөлөөг дээшлүүлнэ.	Эрх зүйн хэм хэмжээ тогтоосон захиргааны актыг нийтэлдэг “Хууль зүйн мэдээлэл” сэтгүүлийг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраар дамжуулан засаг захиргааны анхан, дунд шатны нэгж, байгууллага бүрт хүргэх арга хэмжээ авна.	2009-2012	Орон нутгийн хэмжээнд хууль, тогтоомжийн хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулах, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах, иргэдэд төрийн хууль тогтоомжийг мэдээлэх боломжийг хангах зорилгоор “Хууль зүйн мэдээлэл” сэтгүүлийг төрийн байгууллагууд болон бүх сумдын албан хэрэгцээнд зориулан улирал бүр захиалуулах талаар аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2009 оны 04 дүгээр сарын 01-ний 1/268 тоот хүргүүлсэн. Одоогоор сум бүр ЗДТГ-ын дэргэдэх эрхзүйн туслалцааны төвийн гар санг баяжуулах зорилгоор төрийн мэдээлэл болон хууль зүйн мэдээлэл сэтгүүлийг дугаар алсгалалгүй захиалж байна.	30
149	4.1.3.5		“Эрх зүйн туслалцааны төв”-ийг 21 аймаг, 9 дүүрэгт НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн туслалцаатайгаар байгуулж, үйлчилгээний хүрээг өргөжүүлнэ.	2009-2012	Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 263 дугаар тогтоол, Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2008 оны 02 дугаар сарын 06-ны 27 тоот тушаалаар Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх, эрх зүйн албан бус сургалт сурталчилгаа зохион байгуулах үүрэг бүхий “Эрх зүйн туслалцааны төв”-ийг 2008 оны 8-р сарын 01-ний өдрөөс байгуулан ажиллаж байна. Эрх зүйн туслалцааны төвд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн эрх зүйн сургалт сурталчилгаа хариуцсан ажилтан, өмгөөлөгч, өмгөөлөгчийн туслах нарын бүрэлдэхүүнтэй баг үйл ажиллагаагаа явуулж байна. НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр Хууль зүйн хүртээмж ба Хүний эрх төслийн газраас ирүүлсэн компьютер, тоног төхөөрөмж, бичиг хэрэгсэл тавилга зэрэг эд зүйлийг дээрх төв хүлээн авч үйл ажиллагаандаа ашиглан, төвийн хэвийн ажиллагааг хангах зорилгоор 21615 дугаартай телефон утсыг шинээр тавьж цахим сүлжээнд холбогдон ажиллаж байна.	70
Эрхзүйн бодлогын хэрэгжилт						50
4.2 Гэмт хэрэгтэй тэмцэх бодлого						
150	4.2.1 0.3	Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, архидалт, согтуурлын хор хөнөөлийг бууруулах ажлыг	Согтууруулах ундааны үйлдвэрлэл, үйлчилгээний цэгүүдийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагуудтай хамтран үзлэг шалгалт тогтмол явуулж, гаргасан санал, дүгнэлтийг үндэслэн холбогдох арга хэмжээ авна.	2009-2012	А.Аймгийн хэмжээнд согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхэлдэг 4 үйлдвэрийн үйл ажиллагаанд МХГ, Онцгой байдлын хэлтэс, хамтран шалгалт хийж, 56 зөрчил илрүүлэн, зөрчлийг арилгуулахаар хугацаатай үүрэг өгч биелэлтийг хангуулж ажиллав. Шалгалтын явцад бүтээгдэхүүний түүхий эдийн 19 сорьцонд МХГ-ын лабораторийн шинжилгээ хийлгэж, улсын байцаагчийн дүгнэлт гаргаж технологич, лаборант нарт мэргэжлийн	50

		идэвхжүүлэн, согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдах түүгээр үйлчлэхэд тавих хяналтыг чангатгаж, архинд донтох өвчтэй хүмүүсийг эмчлэх ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх асуудлыг судалж шийдвэрлэнэ.			зөвлөгөө өгч технологийн заавар, ариун цэвэр, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм боловсруулахад мэргэжлийн туслалцаа үзүүллээ. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ХХАА-н сайдын 2004 оны 58 тоот тушаалаар батлагдсан "Согтууруулах ундааны үйлдвэрийн төсөл сонгон шалгаруулах, хяналт тавих журам"-ын дагуу үнэлгээ өглөө. Согтууруулах ундаа худалдаалдаг, түүгээр үйлчилдэг 10 сумын 189 цэгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, нүүдлийн лабораторийг ажиллуулан 536 хүнд Эрүүл мэндийн үзлэг сэргийлэх шинжилгээ хийж, хүнсний бүтээгдэхүүний 2429 сорьцонд хими, хор, нян судлалын шинжилгээ хийлгэн, дүгнэлт гаргаж, лабораторийн шинжилгээгээр чанар аюулгүйн шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг зохих журмын дагуу устгав. Шалгалтаар стандартын шаардлага хангаагүй 12 зоогийн газар, кафе, баар, 38 дэлгүүрийн согтууруулах ундаа худалдаалах, үйлчлэх эрхийг цуцлуулахаар, стандартын шаардлага хангасан 5 кафе, 9 хүнсний дэлгүүрт зөвшөөрөл олгуулахаар аймгийн Засаг даргад санал дүгнэлтээ гаргасны дагуу Засаг даргын 88 дугаар захирамж гаргасан.	
Гэмт хэрэгтэй тэмцэх бодлогын хэрэгжилт					50	
4.3 Хил хамгаалах бодлого						
151	4.3.3.1	Улсын хилийг “хугацаат цэргийн алба хаагч”-аар хамгаалуулдаг тогтолцоог өөрчилж, хил хамгаалах албыг удирдан зохион байгуулах үүргийг мэргэжлийн байгууллагаар, улсын хилийг хамгаалах үүргийг “Мэргэшсэн гэрээт хилчин”-ээр гүйцэтгүүлэх тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлнэ.	Улсын хил хамгаалах үүргийн 50 хүртэлх хувийг гэрээт хилчнээр гүйцэтгүүлэх арга хэмжээ авна.	2009-2012	Хилийн цэргийн мэргэжлийн цэрэгтэй болгох үндэс болсон гэрээт цэргийн талаар орон нутагт сурталчилгаа тогтмол хийж ажилласны дүнд гэрээт цэргийн алба хаах иргэд олон байна. Орон нутгийн талаас гэрээт цэргийн албан хаагчдыг нэмэгдүүлэх хүсэлтэй байгаач Зэвсэгт хүчний жанжин штабаас хяналтын тоог нэмэгдүүлэхгүй байна. Одоогийн байдлаар аймгийн хилийн цэрэгт 14 иргэн гэрээт цэргийн алба хааж үүргээ гүйцэтгэж байна.	30
Хил хамгаалах бодлогын хэрэгжилт						
4.5 Иргэний нийгэм Төрийн удирдлагын бодлого						
152	4.5.4.3	Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын үйл ажиллагааны уялдааг хангасан, иргэнд үйлчлэх	Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлагад нийцүүлэн төрийн захиргааны болон хуульд өөрөөр заагаагүй бол төрийн тусгай	2009	Төрийн албаны тухай хуулийн дагуу 2009 онд 56 удирдах албан тушаалтны ажлын байр, аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, хэлтэс, агентлагаас 81 ажлын байрны захиалгыг орон нутгийн телевиз, сонин, Төрийн албаны зөвлөлөөр дамжуулан төвийн хэвлэл мэдээллийн	100

		үндсэн чиг үүрэг бүхий, авлига, хүнд суртлаас ангид, чадварлаг, хариуцлагатай төрийн албыг хөгжүүлэх чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүнд сурталгүй болгож, хариуцлагыг дээшлүүлнэ.	албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг нээлттэй өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулах журмыг шинэчлэн боловсруулна.		хэрэгслээр нийтэд зарлаж томилогдох ажилтныг хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж байна. Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг Төрийн албаны зөвлөлөөс УИХ-аар батлуулах төсөлд санал боловсруулан хүргүүлсэн.	
153	4.5.4.4		Төсвийн байгууллагын ерөнхий менежерүүдийг манлайлах ур чадвар дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт хамруулан сургаж, чадавхийг бэхжүүлнэ.	2009-2012	Швэдийн олон улсын байгууллагын тусламжтайгаар Завхан аймагт 2009-2010 онд нийт 140 төсвийн ерөнхий менежерүүдийг Манлайллын сургалтанд хамруулан, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын Академид сумын Засаг дарга нарыг 1 удаа, аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан сургалтад сумын Засаг дарга, Тамгын газрын дарга, Багийн Засаг дарга нарыг 2-4 удаа хамруулаад байна.	70
154	4.5.4.5		Төсвийн байгууллагын тогтолцоо, бүтцэд судалгаа хийсний үндсэн дээр тэдгээрийн үйл ажиллагааны уялдааг хангах, иргэдэд үзүүлэх төрийн суурь үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр боловсронгуй болгох арга хэмжээ авна.	2009-2012	Төрийн байгууллагаас иргэдэд хүргэх үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй болгох үүднээс Хүний аюулгүй байдлын судалгааны төвтэй хамтран “Нэг цонхны үйлчилгээ”-г нэвтрүүлээд байна. Тус үйлчилгээний төвөөс 60 гаруй төрийн үйлчилгээг иргэдэд нэг дороос түргэн шуурхай хүргэж байна. Мөн төрийн үйлчилгээг авахад зайлшгүй шаардлагатай байдаг наториад, банкны үйлчилгээг нэг цонхны үйлчилгээний төвд үзүүлж байгаа нь иргэд төрийн үйлчилгээг шат дамжлага багатай авах боломжийг бүрдүүлж өглөө.	90
155	4.5.5.1	Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлж, хууль дээдлэх, авлигыг үл тэвчих ухамсар, соёлыг хэвшүүлж, ажиллах нөхцөл, баталгааг бүх талаар хангах замаар төрийн албыг чадавхижуулна.	Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийг шинээр болон шинэчлэн баталж мөрдүүлэх замаар ажил, үүргийн давхардал, хийдлийг арилгах, төсвийн зардлыг хэмнэх арга хэмжээ авна.	2009	Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 12 сарын 24-ны 67 дугаар тогтоолын дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг 5 хэлтэс, Цэргийн штабтай тогтоон 41 хүртэл орон тоотойгоор үйл ажиллагааг явуулж байгаа бөгөөд Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 19 агентлагтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Сумдын Засаг даргын тамгын газар мөн дээрх тогтоолын дагуу бүтэц орон тоогоо батлан ажиллаж байна.	90
156	4.5.5.2		Төрийн албан тушаал (ажлын байр)-ын чиг үүргийн шинжилгээ, үнэлгээ хийсний үндсэн дээр хүлээх үүрэг, хариуцлагыг нь тодорхой тусгасан ажлын байрны тодорхойлолтыг шинээр боловсруулан баталж мөрдүүлнэ.	2009-2012	2009 онд Засгийн газрын 2008 оны 167 дугаар тогтоолоор бүтэц орон тоо шинэчлэн батлагдсаны дагуу төрийн албан хаагчдийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, ажилчдын ажлын үүрэг хариуцлага, ёс зүйн талаар тусган шинэчлэн боловсруулж баталлаа.	50
157	4.5.5.3		Гадаад, дотоод орчны хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн төсвийн байгууллага бүрийг өөрчлөн хөгжүүлэх замаар байгууллагын	2009-2012	Төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг Төрийн албаны тухай хуулийн дагуу шинэчлэн боловсруулан батлуулсан. Мөн төрийн албан хаагчдийн соёл дэг журам, байгууллагын онцлогт тохирсон	50

			шинэ соёлыг төлөвшүүлэх, төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, баталгааг хангах арга хэмжээ авна.		ёс зүйн дүрэм боловсруулах төсөл боловсруулан ажиллаж байна. Аймгийн төв Улиастай хотод Нутгийн захиргааны ордныг ашиглалтанд оруулж, аймгийн Засаг даргын Тамгын газар, болон хэлтэс агентлагууд, үйлчилгээний газрууд үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн Засаг даргын Тамгын газрын тавилга хэрэгсэл, компьютерийн дэлгэцийг шинэчилж төрийн албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжрууллаа.	
158	4.5.5.4		Төрийн албан дахь авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран хэрэгжүүлж, энэ чиглэлээр үйлчилж буй хууль тогтоомжийг боловсронгуй болгоно.	2009-2010	Аймгийн засаг даргын зүгээс төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангах зорилгоор төрийн бус байгууллагын сүлжээтэй хамтарсан гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд гэрээг үндэслэн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна. Аймгийн хэмжээнд 150 орчим иргэдээс авлига, төрийн байгууллагын хүнд суртлын чиглэлээр судалгаа авахад хүнд сурталтай байгууллагаар Эмнэлгийн байгууллага, Цагдаагийн байгууллага, авлигад өртөх магадлал ихтэй байгууллагаар Цагдаагийн байгууллага, Мэргэжлийн хяналтын байгууллагууд тэргүүлсэн байна. Аймгийн хэмжээний бүх төрийн байгууллагууд 2-3 удаа нээлттэй хаалганы өдрийг зохион байгууллаа. Эхнийхийг аймгийн төв талбайд байгууллагууд хамтарч болон дангаар зохион байгуулсан бөгөөд 2 дахь удаагаа 10 дугаар сарын 20- ний өдрөөр бүх байгууллагууд нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж, тайлан мэдээг Төрийн захиргаа удирдлагын хэлтэс авч нэгтгэж ЗГХЭГ –т хүргүүллээ. Аймгийн ЗДТГ- ын Хууль зүйн хэлтсийн зүгээс 10 сард Цагдаагийн газар, Зэвсэгт хүчний 325 дугаар анги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, шүүхийн шинжилгээний алба зэрэг байгууллагуудын хамтарсан нээлттэй өдөрлөгийг төв талбайд зохион байгуулсан ба мөн 10 дугаар сарын 16 ний өдөр хууль сурталчлах өдөрлөгийг Цагдаагийн газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын алба, хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, Нийгмийн даатгалдын хэлтэс, зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгуулж, өдөрлөгийн хүрээнд оролцсон иргэдээс гаргасан санал хүсэлтээр төлөвлөгөө гарган ЗДТГ- ын даргаар батлуулан холбогдох байгууллагуудад нь хүргэж хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.	70
159	4.5.5.5		Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний дүрмийг шинэчлэн боловсруулж батлан	2009	Төрийн захиргааны албан хаагчдын ёс зүйн дүрмийг шинэчлэн боловсруулах төсөлд саналаа хүргүүлсэн.	100

			мөрдүүлнэ.			
160	4.5.5.6		Төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний дүрмийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шинээр болон шинэчлэн боловсруулж батлан мөрдүүлнэ.	2009	Төрийн тусгай, Төрийн үйлчилгээний албан хаагчдийн ёс зүйн хэм хэмжээний дүрэм боловсруулахад саналаа хүргүүлсэн. Мөн аймаг сумдын засаг даргын тамгын газрын төлөвлөгөөнд албан хаагчдын ёс зүйн талаар тусган хяналт тавьж байна.	100
161	4.5.6.6	Төрийн бодлого, үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний эрх зүйн орчныг боловсронгуй болгож, дүн шинжилгээний чадавхи, үр нөлөөг дээшлүүлнэ.	Яамдын болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтнуудыг хяналт-шинжилгээ үнэлгээ өндөр хөгжсөн орнуудын туршлага судлуулах, энэ чиглэлээрх гадаад, дотоодын сургалтад ээлж дараатай хамруулах замаар ажилтнуудыг чадваржуулж төрийн захиргааны байгууллагуудын хяналт-шинжилгээ, үнэлгээний онол, арга зүйн түвшинг дээшлүүлнэ.	2009-2012	Төрийн захиргааны байгууллагуудын хяналт-шинжилгээ, үнэлгээний онол, арга зүйн мэдлэгийг дээшлүүлэх баруун бүсийн Засаг даргын Тамгын газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтнуудын бүсчилсэн сургалт, семинар 2009 оны 06 сарын 15-17-ны өдрүүдэд Ховд аймагт зохион байгуулагдлаа. Мөн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг удирдлагын академаас зохион байгуулсан сургалтанд хяналт шинжилгээ үнэлгээний тасгийн даргыг хамрууллаа.	50
162	4.5.7.2	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг эдийн засгийн чадавхи, хүн амын тоонд тулгуурлан томсгох, харьцангуй бие даан хөгжих бололцоогоор хангах, төвлөрлийг сааруулах, нэгжийн чиг үүргийг шат бүрээр тодорхойлж удирдлагыг төрийн байгууламжид нийцүүлэн шинжлэх ухааны үндэслэлтэйгээр шинэ түвшинд хүргэж шинэчилнэ.	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд орон нутгийн бие даасан байдлыг хангах чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулна.	2009	Хуульд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбогдуулан орон нутгийн бие даасан байдлыг хангах чиглэлээр санал боловсруулж хүргүүлсэн.	100
163	4.5.7.3		Орон нутгийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэн нутгийн өмчийн тухай бие даасан хуультай болгож, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.	2009-2012	Орон нутгийн өмчийг зүй зохистой ашиглах, ашиглалтыг сайжруулах чиглэлээр анхаарч ажиллаж байна. Орон нутгийн өмчийг захиран зарцуулах тухай аймгийн иргэдийн хурлаар батлагдсан тогтоолыг дагаж мөрдөж байна. Тогтоолын дагуу орон нутгийн өмчийг зарж борлуулах, шилжүүлэх зэрэг арга хэмжээг Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулж иргэдийн хурлаар хэлэлцүүлэн гүйцэтгэж байна.	30
164	4.5.7.4		Орон нутгийн бие даасан байдлыг хангахад чиглэгдсэн жишиг /загвар/ сум шалгаруулах болзлыг баталж хэрэгжүүлнэ.	2009	Жил бүр сум баг, хэлтэс агентлагын ажлыг дүгнэж Тэргүүний сум, баг шалгаруулах болзолыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар батлуулан ажиллаж шалгарсан сумдыг шагнаж урамшуулан ажиллаж байна. Мөнхүү тохижилт бүтээн байгуулалтын жилтэй холбогдуулан Завхан аймгийн Залуучууд оюутны хөгжлийн хөвтэй хамтран “Миний гоё сум” уралдааныг зарлаж, болзлыг бүх сумдад хүргүүлсэн. Тэргүүн байр эзэлсэн сумыг 1 сая, 2,3-р байр эзэлсэн сумдыг тус бүр 500 мянган төгрөгөөр шагнаж урамшууллаа.	100

165	4.5.8.1	Нутгийн өөрөө удирдах болон захиргааны үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож, эрх мэдлийн зохистой харьцаа тогтоон, нутгийн өөрөө удирдах ёсыг жинхэнэ утгаар нь төлөвшүүлэн хөгжүүлнэ.	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай болон Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулж шийдвэрлүүлнэ.	2009-2012	Хуульд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбогдуулан хуулийн төсөлд орон нутгийн бие даасан байдлыг хангах чиглэлээр санал боловсруулж хүргүүлсэн.	30
166	4.5.1.0.1	Төрийн байгууллагын бүтцийг боловсронгуй болгон цомхотгож, төрийн албан хаагчдын давхардсан, сул орон тоог цөөлөх, төрийн зарим чиг үүргийг төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгон төсвийн зарлагын хэмжээг эрс багасгана.	Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны болон сонгосон зарим салбарын нийтлэг болон туслах чиг үүргийг хамарсан стратегийн чиг үүргийн шинжилгээг тусгай төлөвлөгөөний дагуу хийж, чиг үүргийн давхардлыг арилгах, зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгох, орон тоог цөөрүүлэх арга хэмжээ авна.	2009-2012	Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 167 дугаар тогтоолын дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тоог шинэчлэн баталсан. Мөн аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тоог дээрх тогтоолын дагуу дээд хязгаарыг нь хүн ам газар нутгийн байршлаар нь шинэчлэн боловсруулж батлан холбогдох газруудад нь хүргүүлэн биелэлтэд нь хяналт тавин ажиллаж байна. Аймгийн Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын “Өрнөх мүлжээ”ТББ-тай нягт хамтран ажиллаж байна. Үүнд аймгийн төрийн зарим үйл ажиллагаанд тус сүлжээний зарим гишүүдийг оролцуулан хяналт ишнжилгээ үнэлгээ хийлгэсэн.	30
Иргэний нийгэм төрийн удирдлагын бодлогын хэрэгжилт						54
5.1 Гадаад бодлого						
167	5.1.1.14	Нээлттэй олон тулгуурт улс төр, эдийн засгийн дипломат гадаад бодлогын хүрээнд ОХУ, БНХАУ-тай сайн хөршийн түншлэлийн, АНУ, Япон, Европын Холбоотой иж бүрэн түншлэлийн харилцааг, бусад улс орнуудтай тогтоосон найрсаг харилцаа, хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хөгжүүлнэ.	ОХУ, БНХАУ, АНУ, Канад, Япон, ХБНГУ, БНСУ, БНКаЗУ-тай аймаг, хотуудын шууд харилцааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	2009-2012	ОХУ-ын БНТыва улсын Засгийн газрын тэргүүн Каро-Оол Шалбон Валерьевич Улиастай хотод албан ёсны айлчлал хийх үеэр хамтын ажиллагааны гэрээ байгуулж, цаашид мал хөлөөр нь гаргах, мах экспортлох, оюутан солилцох зэрэг асуудлаар хамтран ажиллахаар боллоо. Мөн БНСолонгос улстай хамтын ажиллагаагаа өргөжүүлсний дүнд манай аймагт 150 ширхэг компьютерийн буцалтгүй тусламж үзүүлээ. Тус улсаас манай аймагт “Цөлжилттэй тэмцэх-цөлд тэсвэртэй ургамалыг нутагшуулах” 10 сая долларын өртөгтэй төслийг хэрэгжүүлж эхлээд байна.	50
168	5.1.4.6	Хил, бүс нутгийн хамтын ажиллагаа хөгжүүлэх таатай нөхцөлийг хангах талаар холбогдох талуудтай ажиллана.	Хил, бүс нутгийн хамтын ажиллагаа хөгжүүлэх таатай нөхцөлийг хангах талаар холбогдох талуудтай ажиллана.	2009-2012	Хил залгаа орших ОХУ-ын Тува улсын засгийн газрын тэргүүн манай аймагт айлчилж, айлчлалын хүрээнд хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурлаа. 2010 оны 5 сард манай аймгийн удирдлагууд БНТува улсад албан ёсны айлчлал хийхээр 2 тал харилцан тохиролцоод байна. Хоёр тал хамтран хил дамнасан малын хулгай, хилийн зөрчлийг багасгах талаар хамтран ажиллаж мэдээлэл солилцож байна.	50
Гадаад бодлогын хэрэгжилт						50

5.2 Батлан хамгаалах бодлого						
169	5.2.7.1	Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг орон нутагт бэлтгэх тогтолцоог төгөлдөршүүлж, бүсийн төвүүдэд байршилтай зэвсэгт хүчний анги, салбарыг түшиглэн бүсийн сургалт явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.	Дайчилгааны I, II зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтын чанар, оролцох бүрэлдэхүүнийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	2009-2012	Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх байртай болох талаар 2 сая төгрөг тусгагдсан. Аймгийн Засаг даргын 2009 оны 1 дүгээр сарын 27 ны өдрийн 17 дугаар захирамжаар тус асуудлын талаар үнэлэлт гаргах үнэлгээний хороо байгуулагдсан. Сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу дайчилгааны бэлтгэл нөөцийн цэргийн чухал мэргэжил бүхий нэгдүгээр цэргийн үүрэгтэн цэрэг түрүүч 60 хүнийг п-575, Ж-635, Ж-486, И-619, П-113, Ж-113 мэргэжлээр орон нутагт 40, цэргийн ангийг түшиглэн 20 хүнийг тус тус сургалаа.	30
Батлан хамгаалах бодлогын хэрэгжилт						
5.3 Гамшгаас сэргийлэх, хор хөнөөлийг арилгах үндэсний чадавхи бэхжүүлэх бодлого						
170	5.3.4.2	Мэргэжлийн хяналтын байгууллагыг орчин үеийн техник, технологи бүхий нэгдсэн лабораторитой болгож, материаллаг баазыг нь бэхжүүлэн, боловсон хүчний чадавхийг сайжруулна.	Төв, орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын материаллаг бааз, хүний нөөцийн чадавхийг сайжруулж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авна.	2010-2012	Хими, хор судлал, микробиологины лаборатори нь 3 дээд мэргэжлийн 1 дунд мэргэжлийн ажилтантай, цаашид бүх ажилтнаа дээд мэргэжлийн болгох зорилт тавин ажиллаж байна. Мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн лаборатори нь Бетон гадаргуугийн цохилтын бат бөхийг тодорхойлогч багаж Concrete, Электрон нивилер-Electro niveler, Хүчдэлийн детектор-Voltage Detector, Элиза уншигч-ELISA Reader, pH-метр-pH-meter, Аналитик жин-Analytic balance, Ламинар бокс-Laminar Flow Cabinet, Анэробик систем-Anaerobic System, Зейцийн аппарат филтер-Filtration Assemblies, Зейцийн аппарат колба-Filtering Flasks, Зейцийн аппарат мембран-Sterile Mixed Cellulose Ester Filter Membranes, Зейцийэ аппарат шахуурга-Motor зэрэг /нийт 16696100 төгрөг/ багаж тоног төхөөрөмжөөр хангагдан ажиллаж байна. Мөн Мотор, Давхар ус нэрэгч, Колони тогтоогч, Дээж бутлагч, Термостат, PCR Vidas, Сорох шүүгээ, Автоқдав 220V, Гравын камер, Магнитны мьшалк, Автомат пипетка хатаагч, Электрон жин, ASS атом шингээлтийн спектрофотометр, Центрифуг автомат тохируулгатай, Пивоны шинжилгээний багаж, RIDA COUNT-ийн ком тест, Комьпютер, Aflatoxin Total, Цианид тодорхойлох хурдавчилсан аргын тест, Аспиратор, Меркуриметр зэрэг багаж тоног төхөөрөмжийг авахаар УИХ-н гишүүн Сайхансамбууд уламжлаад байна.	50
171	5.3.4.3		Хилийн боомтуудын мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн орон тоог нэмэгдүүлж, зайлшгүй шаардлагатай багаж, техник хэрэгслээр ханган, ажлын болон	2009-2012	Арц суурийн хилийн мэргэжлийн хяналтын хэлтэст стандарт чанарын хяналтын улсын байцаагч-1, нийт 2 орон тоо нэмэгдэн ажиллаж байна. Ажлын байртай болж, лабораторийн багаж тоног төхөөрөмжөөр хангалаа.	90

		ахуйн байртай болгоно.			
Гамшгаас сэргийлэх, хор хөнөөлийг арилгах үндэсний чадавхи бэхжүүлэх бодлогын хэрэгжилт					70
Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн нийт дүн					41,05

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.НЯМЖАВ

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудын хэрэгжилтийн товчоо

/Арга хэмжээний тоогоор/

		2008-2012	2009	2009-2010	2009-2011	2009-2012	2010	2010-2011	2010-2012	2011-2012	Нийт	
Нийт		19	7	16	3	116	1	1	6	2	171	
Үүнээс	Биелсэн		5			1				1	7	
	Хэрэгжих шатандаа	Бүгд	18	2	16	3	113	1	1	6		163
		90%		1			2					3
		70%			1		2			1		4
		50%	12	1	6	1	45	1		4		70
		30%	5		8	2	53		1	1		70

	10%	1		1		11						13
	Тасарсан	1				2						3
	Хугацаа болоогүй									1		1
Хэрэгжилтийн хувь		40	91,4	38,75	36,6	37,6	50	30	50	100		41,05

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.НЯМЖАВ